

**“ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**



40

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**





"ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ЭРХЭМ ЗОРИЛГО

*Эх орны хөгжлийн баталгаа
Эрчим хүчний хүчирхэг тулгуур нь байна.*

ХЭТИЙН ЗОРИЛГО

*"ДЦС-4" ТӨХК 2030 он гэхэд инновацид суурилсан
эрчим хүчний цогц бүтээгдэхүүн ажил үйлчилгээтэй
шилдэг компани болно.*

1983-2023

ДЦС-4

ANNIVERSARY

th

ҮНЭТ ЗҮЙЛС

ЭВСЭГ ХАМТАЧ
ЭРЧ ХҮЧТЭЙ
ЧАДВАРЛАГ МЭРГЭШСЭН
ИДЭВХИ САНААЧЛАГАТАЙ
МАНЛАЙЛАГЧ

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

08

Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын зөвлөл

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

12

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт, Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай, Засварын ажлын талаар, Техник, технологийн шинэчлэл, төсөл

АГУУЛГА

20

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын санал, дүгнэлт, Аудитлагдсан санхүүгийн тайлан, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн чадавхийн шинжилгээ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд, Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр

47

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

Хүний нөөц, Ил тод, ёс зүйн байдал, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

41

31

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар, Санхүүгийн дотоод аудит, MNS ISO9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт, Тарифын зохицуулалт, Эрчим хүчний эх үүсвэрүүдийн 2023 оны үнийн судалгаа

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ, Эрчим хүчний системд эзлэх байр суурь

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

08

Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын зөвлөл

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

12

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшингийн биелэлт, Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай, Засварын ажлын талаар, Техник, технологийн шинэчлэл, төсөл

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

20

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын санал, дүгнэлт, Аудитлагдсан санхүүгийн тайлан, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн чадавхийн шинжилгээ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд, Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр

47

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

Хүний нөөц, Ил тод, ёс зүйн байдал, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

41

31

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар, Санхүүгийн долоод аудит, MNS: ISO9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт, Тарифын зохицуулалт, Эрчим хүчний эх үүсвэрүүдийн 2023 оны үнийн судалгаа


КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“ДЦС-4” ТӨХК-ийн суурийг 1979 онд тавьж, 1983 онд эхний агрегат 80 МВт, 1984 онд 2 агрегат бүхий 180 МВт, 1985 онд 3 агрегат бүхий 280 МВт, 1986 онд 4 агрегат бүхий 380 МВт, 1990 онд 5 агрегат бүхий 460 МВт, 1991 онд 6 агрегат бүхий 540 МВт-ын суурилагдсан хүчин чадалтай болсон бөгөөд өөрийн инженерүүдийн санаачлагаар хүчин чадлыг 2007 онд 20 МВт-аар нэмэгдүүлсэн. 2015 онд Турбоагрегат №7-г шинээр ашиглалтанд оруулж, 2019-2020 онд Турбоагрегат №1-4-г шинэчилсэнээр нийт 772 МВт цахилгаан эрчим хүчний, 1586 Гкал дулааны эрчим хүчний суурилагдсан хүчин чадалтай ажиллаж байна.

Тус компанийн эзэмшилд захиргааны, ахуй үйлчилгээний, лабораторийн, үйлдвэрлэлийн, засварын зэрэг 66,7 га талбай бүхий 89 барилга, 174 байгууламж багтдаг бөгөөд төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 54,4 хувийг, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 55,1 хувийг дангаараа үйлдвэрлэн хэрэглэгчдийн тав тухтай байдлыг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2001 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 164 дүгээр тогтоолоор Дулааны IV цахилгаан станцыг бие даасан Төрийн өмчит хувьцаат компани болгон зохион байгуулсан. Хувьцааны 70 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар тус тус эзэмшиж байна.

Бүтэц зохион байгуулалт



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



2023 онд “ДЦС-4” ТӨХК цахилгаан, дулааны эрчим хүчний боловсруулалт, түгээлтийн төлөвлөгөөг давуулан биелүүлж, ДХЦЭХ-ийг хэмнэж, жишмэл түлшний хувийн зарцуулалт, нэгжийн өөрийн өртгийг бууруулан 436.3 тэрбум төгрөгийн орлоготой ажиллан төлөвлөгөөг 105.4 хувиар биелүүлж зорилтот түвшин, техник эдийн засгийн үзүүлэлтүүдийг бүрэн биелүүлсэн байна.

2024 онд манай хамт олон амжилтаа бататган, хэрэглэгчдээ цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж ажиллана гэдэгт итгэл дүүрэн байна.

Сайн үйлс дэлгэрэх болтугай.

“ДЦС-4” ТӨХК-ийн 2023 оны үйл ажиллагааны тайланг хүргүүлж байгаа энэ мөчид компанийн нийт хамт олон, хамтран ажилласан Эрчим Хүчний Яам, Сангийн Яам, Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар, Эрчим хүчний зохицуулах хороо, МУ-ын Хөгжлийн Банк, бусад түнш байгууллагууддаа ТУЗ-ийн нэрийн өмнөөс болон хувиасаа мэндчилгээ дэвшүүлж байна.

2023 онд “ДЦС-4” ТӨХК нь цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийг тасралтгүй явуулж, горим параметрийн даалгаврыг бүх төрлөөр нь биелүүлэн ажиллалаа.

Б.Ерэн-Өлзий
ТУЗ-ийн дарга, Эрчим хүчний яам, Бодлого
төлөвлөлтийн газрын дарга

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

“ДЦС-4” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн Удирдах Зөвлөл, хамтран ажилладаг түнш байгууллагууд болон нийт хамт олон тэдний гэр бүл, мөн бодлого, шийдвэрээр дэмжин ажиллаж ирсэн Улсын Их Хурал, Засгийн Газар, Сангийн яам, Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрчим хүчний зохицуулах хороо болон бусад байгууллага хамт олонд талархсанаа илэрхийлье.

Дулааны 4-р цахилгаан станцын хамт олон бид улиран өнгөрч буй 2023 он - түүхт 40 жилийн ойн жилдээ Монгол улсын Төвийн бүсийн цахилгаан эрчим хүчний 54,4%-ийг, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний 55.1%-ийг дангаар хангаж, хүчин чадал ашиглалтыг 73%-д хүргэж бахдам амжилт гарган ажиллалаа. 2023-2024 оны өвлийн их ачааллын энэ өдрүүдэд 8 зуух, 7 уурын турбинтэйгээр 720 МВт ачаалалтай ажиллаж байгаа хамт олондоо гүн талархал илэрхийлье.

Бид 2023 онд 4,3 тэрбум кВт.цаг цахилгаан эрчим хүчийг түгээсэн бөгөөд өмнөх онтой харьцуулахад 218.0 сая кВт.цаг-аар илүү үйлдвэрлэснээр Эрчим хүчний системийн санхүүгийн тэнцэлд эерэг үр дүнг үзүүллээ.

Манай хамт олон компанийнхаа 40 жилийн ойн хүрээнд төлөвлөгөөт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийг 105.4%-иар, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийг 100%-иар биелүүллээ.

2023 онд үндсэн болон туслах тоноглолын их засварын ажлыг өвлийн их ачааллын өмнө



дуусгаж, үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлэн, найдвартай ажиллагааг ханган цахилгаан, дулаан үйлдвэрлэх эрхэм зорилгоо амжилттай хэрэгжүүлж ажиллалаа.

Бидний гүйцэтгэж байгаа үүрэг, хариуцлага Эрчим хүчний салбарын найдвартай байдлын баталгаа болж байгаа тул 2024 онд төлөвлөсөн засвар, шинэчлэлийн ажлаа амжилттай хийж, ирэх өвлийн ачаалалыг амжилттай давах бэлтгэлээ ханган ажиллахаа хамт оныхоо өмнөөс илэрхийлье.

Та бүхэндээ ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе.

Ү.Төмөрхуяг

“ДЦС-4” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ, Эрчим хүчний системд эзлэх байр суурь

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

08

Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын зөвлөл

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

12

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгог түвшингийн биелэлт, Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай, Засварын ажлын талаар, Техник, технологийн шинэчлэл, төсөл

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

20

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын санал, дүгнэлт, Аудитлагдсан санхүүгийн тайлан, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн чадавхийн шинжилгээ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд, Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр

47

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

Хүний нөөц, Ил тод, Ёс зүйн байдал, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

41

31

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар, Санхүүгийн дотоод аудит, MNS-ISO9001:2016 Манарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт, Тарифын зохицуулалт, Эрчим хүчний эх үүсвэрүүдийн 2023 оны үнийн судалгаа

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН ГИШҮҮД



ТУЗ-ийн дарга, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга
Б.Ерэн-Өлзий



ТУЗ-ийн гишүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газар, ахлах шинжээч
Ё.Энхтуяа



ТУЗ-ийн гишүүн, Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, шинжээч
Н.Амартөвшин



ТУЗ-ийн гишүүн, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Салбарын бодлого зохицуулалтын газрын референт
Д.Болд



ТУЗ-ийн гишүүн, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Салбарын бодлого зохицуулалтын газрын шинжээч
Б.Очирпүрэв



ТУЗ-ийн гишүүн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Төрийн өмчийн ашиглалтын хэлтэс, мэргэжилтэн
Л.Гэрэлмаа

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



ТУЗ-ийн хараат бус гишүүн, МЭХИХ-ны Гүйцэтгэх захирал
Р.Ганжуур



ТУЗ-ийн хараат бус гишүүн, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний зохицуулах зөвлөлийн дарга
Ж.Батсуурь



ТУЗ-ийн хараат бус гишүүн, Барилгын хөгжлийн төвд лаборант
Ш.Ариунжаргал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнээр Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын референт Д.Болд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого зохицуулалтын газрын шинжээч Б.Очирпүрэв, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Ё.Энхтуяа, Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч Н.Амартөвшин, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Төрийн өмчийн ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн Л.Гэрэлмаа, хараат бус гишүүнээр Монголын эрчим хүчний инженерүүдийн холбооны гүйцэтгэх захирал Р.Ганжуур, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний зохицуулах зөвлөлийн дарга Ж.Батсуурь, Барилгын хөгжлийн төвд лаборант Ш.Ариунжаргал нар ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Н.Мягмар, хараат бус гишүүн Г.Пүрэвдорж, В.Бат-Эрдэнэ нар чөлөөлөгдсөн.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэн, Эрчим хүчний сайдын өгсөн удирдамж чиглэлийн дагуу компанийн 2023 оны бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, компанийн ажилтнуудад 2022 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, компанийн зохион байгуулалтын бүтэц, компанийн ажилтнуудын цалинг нэмэгдүүлэх, 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөний биелэлтийг танилцуулах, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах, компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан, 2023 оны зардлын төсөв, Аудитын хорооны тайлан, ногдол ашгийн тухай, техник эдийн засгийн үндсэн үзүүлэлт, худалдан авалтын төлөвлөгөөний тодотголыг батлах, компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, их засвар, техник зохион байгуулалтын арга хэмжээ, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийн тухай зэрэг асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд 10 удаа цахимаар хуралдаж, Эрчим хүчний сайдын удирдамжийн дагуу 24 асуудал хэлэлцэж, 18 тогтоол, 6 тэмдэглэл гаргасан.



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ



Зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал
Ү.Төмөрхуяг



Зөвлөлийн гишүүн,
Ерөнхий инженер
П.Болдбаатар



Зөвлөлийн гишүүн,
Захиргаа, хүний
нөөцийн албаны дарга
Ш.Туухайнжин



Зөвлөлийн гишүүн,
Хяналтын албаны дарга
Ж.Энхцогт



Зөвлөлийн гишүүн,
Судалгаа хөгжлийн албаны
дарга **Г.Галбадрах**



Зөвлөлийн гишүүн,
Үйлдвэрлэлийн албаны дарга
Б.Батзориг



Зөвлөлийн гишүүн,
Төлөвлөлт эдийн засгийн
хэлтсийн дарга
Ц.Өсөхнэмэх



Зөвлөлийн гишүүн, Санхүү
бүртгэлийн хэлтсийн дарга
Б.Цэндээ



Зөвлөлийн гишүүн,
Зуухан цехийн дарга
Л.Ганболд



Зөвлөлийн гишүүн,
ДХХАЦ-ийн дарга
Б.Батцэрэн



Зөвлөлийн гишүүн,
Нийгэм ахуйн хэлтсийн
дарга
Б.Төрбат



Зөвлөлийн НБ-ийн дарга,
Захиргаа, хүний нөөцийн
албаны Захирлын туслах
Ч.Нарангэрэл

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ, Эрчим хүчний системд эзлэх байр суурь

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын зөвлөл

08

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт, Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай, Засварын ажлын талаар, Техник, технологийн шинэчлэл, төсөл

12

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

20

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын санал, дүгнэлт, Аудитлагдсан санхүүгийн тайлан, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн чадавхийн шинжилгээ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд, Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр

47

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

Хүний нөөц, Ил тод, ёс зүйн байдал, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

41

31

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар, Санхүүгийн дотоод аудит, MNS ISO9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт, Тарифын зохицуулалт, Эрчим хүчний ах үүсвэрүүдийн 2023 оны үнийн судалгаа

ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ

2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн үзүүлэлтийг Эрчим хүчний сайдын 2022 оны 12-р сарын 11-ний өдрийн А/291 тоот тушаалаар батлуулан ажилласан. Бизнес

төлөвлөгөөнд тодотгол хийж, Эрчим хүчний сайдын 2023 оны 08-р сарын 16-ны өдрийн А/178, 2023 оны 12-р сарын 11-ний өдрийн А/291 тоот тушаалаар батлуулан мөрдөн ажилласан.

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2022 оны гүйц	2023 оны		Зөрүү	
					төлөв	гүйц	төл-нөөс	хувиар
1	Боловсруулсан	ЦЭХ	сая кВт.ц	4,637.6	4,648.1	4,871.4	223.3	104.8
		ДЭХ	мян.Гкал	4,551.4	4,721.1	4,636.9	-84.2	98.2
	ДХЦЭХ-ний зарцуулалт	хувиар	%	11.34	11.45	11.12	-0.33	97.16
		биетээр	сая кВт.ц	526.1	532.2	541.9	9.7	101.8
	Эрчим хүч түгээлт	ЦЭХ	сая кВт.ц	4,111.5	4,115.9	4,329.5	213.6	105.2
		ДЭХ	мян.Гкал	4,551.4	4,721.1	4,636.9	-84.2	98.2
2	Нийт орлого		сая төг	331,435.7	413,780.0	436,301.5	22,521.4	105.4
	Үүнээс: Борлуулалтын орлого		сая төг	319,326.1	409,608.9	430,276.9	20,668.0	105.0
	Үйл ажил-ны бус орлого		сая төг	12,109.6	4,171.1	6,024.5	1,853.4	144.4
3	Нийт зардал		сая төг	381,490.5	422,018.9	430,624.4	8,605.4	102.0
	Үүнээс: Үйл ажиллагааны зардал		сая төг	336,631.7	417,847.8	423,678.4	5,830.6	101.4
	Үйл ажиллагааны бус зардал		сая төг	44,858.8	4,171.1	6,945.9	2,774.8	166.5
	Үүнээс: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал		сая төг	-39,583.8	62,397.5	65,694.5	3,297.0	105.3
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	-50,054.8	-8,238.9	5,677.1	13,916.0	-68.9
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая төг	-50,409.6	-8,238.9	1,161.9	9,400.8	-14.1
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.05	1.02	0.99	-0.03	96.77
7	Нийт авлага		сая төг	19,604.3	15,850.0	22,049.0	6,199.0	139.1
	Үүнээс:	ЭХ-ний	сая төг	17,470.5	15,000.0	21,556.2	6,556.2	143.7
		бусад	сая төг	2,133.7	850.0	492.8	-357.2	58.0
8	Нийт өглөг		сая төг	484,245.0	465,630.6	466,702.2	1,071.6	100.2
	Үүнээс:	УХӨТ	сая төг	329,338.3	272,601.6	427,452.2	154,850.7	156.8
		БХӨТ	сая төг	154,906.7	193,029.0	39,250.0	-153,779.0	20.3
9	Нийт ажиллагсад		Тоо	1,487	1,487	1,487	0	100
10	Нийт цалингийн сан		сая төг	49,900.0	62,813.7	62,813.1	-0.6	100.0
11	Жишмэл түлшний хувийн зарцуулалт	цахилгаан	гр/кВт.ц	270.88	274.76	271.95	-2.82	98.97
		дулаан	кг/Гкал	171.66	172.51	171.69	-0.82	99.52
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая төг	27,005.8	36,475.0	34,031.5	-2,443.5	93.3

ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТИЙН ТУХАЙ

Цахилгаан эрчим хүчний боловсруулалт

4,871.4 сая.кВтц ЦЭХ боловсруулан төлөвлөгөөг 104.8 хувиар биелүүлж, төлөвлөсөнөөс 223.3 сая. кВтц ЦЭХ илүү үйлдвэрлэсэн. ЦЭХ-ний боловсруулалт өмнөх оноос 233.8 сая.кВтц-аар өссөн.

Дотоод хэрэгцээний ЦЭХ-ний хэмжээ 11.12% болж төлөвлөгөөнөөс 0.33 нэгж хувиар буюу 15.9 сая. кВтц-аар буурч, 727,6 сая төгрөгийн борлуулалтын орлого олох боломжийг бий болгосон.

Цахилгаан эрчим хүчний түгээлт






4,329.5 сая.кВтц Цахилгаан эрчим хүч түгээж, төлөвлөгөөг 105.2 хувиар биелүүлэн 213.6 сая. кВтц ЦЭХ илүү түгээсэн. 2022 онтой харьцуулахад 218.0 сая. кВтц-аар буюу 5.3%-аар өссөн.


Дулааны эрчим хүчний түгээлт

4,636.9 мянган Гкал дулааны эрчим хүч түгээж, төлөвлөгөөг 98.2 хувиар, диспетчерийн графикийг 100% биелүүлж ажилласан. Төлөвлөгөөтэй харьцуулахад 84.1 мянган Гкал-аар, 2022 онтой харьцуулахад 85.6 мянган Гкал-аар тус тус өссөн.

Жишмэл түлшний хувийн зарцуулалт


Жишмэл түлшний хувийн зарцуулалт цахилгаанд 271.947 гр/кВтц, дулаанд 171.686 кг/Гкал байгаа нь төлөвлөгөөтэй харьцуулахад цахилгаанд 3.016 гр/кВтц-аар, дулаанд 0.433 кг/Гкал-аар тус тус буурсан байна. Өмнөх онтой харьцуулахад цахилгаанд 1.069 гр/кВтц-аар, дулаанд 0.025 кг/Гкал-аар өссөн байна.






Нийт орлого

Нийт **436.3** тэрбум төгрөгийн орлоготой ажиллан төлөвлөгөөг **105.4** хувиар биелүүлж, орлого төлөвлөсөнөөс **22.5** тэрбум төгрөгөөр өссөн. Цахилгаан эрчим хүчний борлуулалтын орлого төлөвлөсөнөөс **18.1** тэрбум төгрөгөөр, дулааны эрчим хүчний борлуулалтын орлого **2.6** тэрбум төгрөгөөр тус тус өссөн. 2023 оны нийт орлогын өсөлтийн **20.7** тэрбум төгрөг нь цэвэр борлуулалтын орлого, **1.9** тэрбум төгрөг үйл ажиллагааны бус орлого байна. Нийт орлогыг 2022 онтой харьцуулахад **104.9** тэрбум төгрөгөөр өссөн.



Нийт зардал

Нийт **430.6** тэрбум төгрөгийн зардалтай ажиллаж, төлөвлөгөөнөөс **8.6** тэрбум төгрөгөөр өссөн. Үйл ажиллагааны зардал **5.8** тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь цахилгаан, дулааны эрчим хүчний түгээлтийн өсөлтөөс ашиглалтын ЦЭХ, ДЭХ-ний зардал **3.4** тэрбум төгрөгөөр, элэгдлийн зардал **3.3** тэрбум төгрөгөөр, ажиллагсдын нийгмийн зардал **1.7** тэрбум төгрөгөөр тус тус өссөнтэй холбоотой. Үйл ажиллагааны бус зардал **2.8** тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь валютын ханшийн бодит бус алдагдалд **2.3** тэрбум төгрөг бичигдсэн нь нөлөөлсөн.



Зардлын бүтэц

Нийт зардлын **50.6%**-ийг түлшний зардал, **15.3%**-ийг үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийн зардал, **14.5%**-ийг цалин, **18.0%**-ийг бусад тогтмол зардал, **1.6%**-ийг үйл ажиллагааны бус бусад зардал эзэлж байна.

Орон тоо, цалингийн сан

Компани 2023 онд **1487** хүний орон тоотой ажилласан. Үүнд: Удирдлага **2**, инженер техникийн ажилтан **335**, ажилчид **1150** байна.


Нийт цалингийн санд **62,813.1** сая төгрөг зарцуулан төлөвлөсөнөөс **0.6** сая төгрөгөөр хэмнэсэн. Дундаж цалин **3,520.1** мянган төгрөг болж, өмнөх оноос **710.4** мянган төгрөгөөр өссөн.

Ашигт ажиллагаа

2023 онд **8,238.9** сая төгрөгийн татварын өмнөх алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр **5,677.1** сая төгрөгийн ашигтай ажиллан, төлөвлөсөнөөс **13,916.0** сая төгрөгөөр өссөн.

Үйл ажиллагаанаас **6,598.5** сая төгрөгийн ашигтай ажиллаж, төлөвлөсөнөөс **14,837.4** сая төгрөгөөр өссөн.

ЦЭХ-ний нэгжийн өөрийн өртөг **63.40** төгрөг байгаа ба 1 кВтц ЦЭХ-ийг дунджаар **89.69** төгрөгөөр борлуулж, нэгжээс **26.29** төгрөгийн, нийт ЦЭХ-ний үйлдвэрлэлтээс **113,817.4** сая төгрөгийн ашигтай ажилласан.



ДЭХ-ний нэгжийн өөрийн өртөг **32,175.58** төгрөг байгаа ба 1 Гкал ДЭХ-ийг дунджаар **9,052.49** төгрөгөөр борлуулсан нь нэгжээс **23,123.09** төгрөгийн, нийт ДЭХ-ний үйлдвэрлэлтээс **107,218.9** сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Борлуулалтын орлогын нэг төгрөгт ноогдох зардал

Борлуулалтын орлогын 1 төгрөгт ноогдох зардал **0.987** төгрөг гарч төлөвлөсөн хэмжээнээс **0.033** төгрөгөөр буурсан байна.

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажилд **36,475.0** сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс **34,031.5** сая төгрөг зарцуулж **2,443.5** сая төгрөгөөр хэмнэгдсэн. Төлөвлөгөөт ажлуудыг хийж гүйцэтгэснээр өвлийн их ачааллыг амжилттай давсан. Үндсэн тоноглолын их засварт **23,922.4** сая төгрөг зарцуулж **1,238.6** сая төгрөгөөр хэмнэгдсэн.


Туслах тоноглолын засварын ажилд **6,661.1** сая төгрөг төлөвлөж **6,033.8** сая төгрөг зарцуулж **627.3** сая төгрөг хэмнэсэн.

ТЗБАХ-ний 1 ажилд **56.0** сая төгрөг төлөвлөж, ажлыг гүйцэтгэсэн.


Хөрөнгө оруулалтын 10 ажилд **1,840.6** сая төгрөг төлөвлөж **1,448.9** сая төгрөг зарцуулсан. 9 ажил бүрэн дууссан, 1 ажил он дамжиж хийгдэнэ.

Авлага

2023 онд **22,049.0** сая төгрөг болж оны эхнээс **2,444.7** сая төгрөгөөр өссөн. НХАЗ-ын авлага **21,241.4** сая төгрөг болж оны эхнээс **4,682.2** сая төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Бусад авлага оны эхнээс **1,641.0** сая төгрөгөөр, төлөвлөгөөнөөс **357.2** сая төгрөгөөр буурсан байна. Нийт авлагын **95.7** хувийг эрчим хүчний байгууллагаас авах авлага эзэлж байна.



Өр төлбөр



Нийт өр төлбөр **466.7** тэрбум төгрөг болж оны эхнээс **17,542.8** сая төгрөгөөр буурсан ба урт хугацаат өглөг **98,113.9** сая төгрөгөөр өсөж богино хугацаат өглөг **115,656.7** сая төгрөгөөр буурсан байна.

ТА-1-4-ийн шинэчлэлийн төслийг хэрэгжүүлэхээр Хөгжлийн банкнаас авсан зээлээс **70,638,904.87** еврогийн зээлийн үлдэгдэлтэй байна. Монгол улсын Засгийн Газраас цахилгаан, дулааны эрчим хүчний үнэ

тарифыг нэмэгдүүлээгүй учир Хөгжлийн банкны зээлийн үндсэн төлбөрийг төлөх эх үүсвэрг үнэ тарифт тусгагдаагүй тул Монгол Улсын Хөгжлийн банканд удаа дараа хандаж зээлийн гэрээний нөхцөлд "Үндсэн төлбөр төлөх хугацааг **3** жилээр хойшлуулах, валютыг төгрөгт шилжүүлэх" өөрчлөлт оруулсан. Зээл төлөлтийн хуваарьт өөрчлөлт орсны дагуу 2023 оны санхүүгийн тайланд НББОУС-10-ын дагуу **43,782,621.92** евро буюу **166,008.8** сая төгрөгийг урт хугацаат өр төлбөрт тайлагнасанаар урт хугацаат өглөг төлөвлөсөнөөс **154,850.7** сая төгрөгөөр өссөн ба тухайн жилд төлнө гэж богино хугацаат өглөг рүү төлөвлөсөн нь төлөгдөөгүй тул богино хугацаат өглөг **153,779.0** сая төгрөгөөр хэмнэгдсэн.

ЗАСВАРЫН АЖЛЫН ТАЛААР

Үндсэн тоноглолын графикт засвар

2023 онд төлөвлөгөөт 5 тоноглолд их засвар, 4 тоноглолд дунд засвар хийхээр төлөвлөгдсөн. Үүнд: Зуух №3, Зуух №7, Үнсэн сангийн карт №2 /Үнсэн сан №2/-н их засвар, ТА №6-н их засвар блокын хамт, Зуух №1, 5-н дунд засвар, ТАН№7, Блок №7-ийн дунд засварууд 100%-н гүйцэтгэлтэйгээр хийгдэж дууссан.

Туслах тоноглолын их засвар

2023 онд тодотголоор **101** тоноглолд их засвар хийхээр төлөвлөгдсөн. **85** тоноглолд засварын ажил бүрэн хийгдэж, **14** тоноглолын засвар он дамжин хийгдэхээр, **2** тоноглол хасагдаж засварын ажлын биелэлт **98.7%**-тай байна.

2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө

Тус ажлын хүрээнд **7** бүлэг **24** ажлын төлөвлөгөө гарган ажилласан. Төлөвлөгөөний биелэлт – **100%**-тай байна.

Хэсэгчилсэн зогсолтын засвар

2023 оны хэсэгчилсэн зогсолтоор станцын хэмжээнд нийт **448** ажил төлөвлөсөн ба үндсэн засвар үйлчилгээний **420** ажлуудыг бүрэн гүйцэтгэж **94%**-ийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн.

Манай компани 2023 онд үндсэн ба туслах тоноглол их, дунд засварыг батлагдсан графикт хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэх, тоног төхөөрөмжийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт урсгал засвар, аваарийн эвдрэл, гэмтлийг тухай бүр шуурхай арилгах ажлыг зохион байгуулалтаар хангаж гүйцэтгэлийн хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллалаа.

2023 онд станцын дүнгээр:

Засварын төрөл	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Үндсэн тоноглолын засвар	25,161.0	25,709.6
Туслах тоноглолын их засвар	6,187.1	6,008.3
Туслах тоноглолын урсгал засвар	5,413.2	5,363.5
ДҮН	37,235.3	37,081.4

Гэрээгээр хийгдсэн ажил:

2023 онд тоног төхөөрөмжийн их, урсгал засвараар нийт **25** тоноглолын их засварыг гэрээ байгуулан гүйцэтгүүлж дууссан.

Он	Үндсэн тоноглол	Туслах тоноглол	Үйлчилгээ	Дүн
2021 онд	7	15		22
2022 онд	9	13		22
2023 онд	9	14	2	25

ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ, ТӨСӨЛ

УС ДАХИН БОЛОВСРУУЛАХ ТӨСӨЛ



МОНГОЛЫН МЯНГАНЫ СОРИЛТЫН САХ
MILLENNIUM CHALLENGE ACCOUNT - MONGOLIA

Монгол Улсын Засгийн Газар, АНУ-ын Мянганы Сорилтын Корпорацийн хамтран хэрэгжүүлж байгаа “Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийн “Хаягдал ус дахин боловсруулах” төслийн зөвлөх Герман улсын “FICHTNER” компани болон хамтрагч Монгол улсын “ИКОН Консалтинг” ХХК станц дээр хийгдэх ажлуудтай танилцан зураг төсөл боловсруулахад шаардлагатай материал бэлдэх, трассыг тохиролцох зэрэг ажлуудаа хийсэн. “Икон Консалтинг” ХХК-ийн туслан гүйцэтгэгч болох геодизийн үйлчилгээ үзүүлэх “Галгэр” ХХК-ийн мэргэжилтэнгүүд Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрээс (ХУДБҮ) ирэх усны шугамын трасс дагуух хэмжилт, газар доорх биетийн илрүүлэлт хийж дэвсгэр зургуудыг станцын хашааны гадна болон дотор талд гаргасан зургууддаа олон улсын хэмжээнд тендер зарласантай холбогдуулан нарийвчлан нягтлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

ХУДБҮ-ээс станц хүрэх үндсэн трасс болон станцын хашаан доторх трассын дагуу байгаль орчин, амьтан ургамалд хэрхэн нөлөөлөх, нөлөөллийг тодорхойлохоор “Экотрэйд” ХХК-ийн мэргэжилтэнгүүд мөн ажилласан. Мөн Мазут аж ахуйн цахилгааны 0,4 кВ –ын хуваарилах байгууламжийг бүрэн шинэчлэхтэй нарийвчилсан судалгаа, ММСС-аас станцын ЦЦ-тэй хамтран гүйцэтгэж, хуваарилах байгууламжид тавигдах релей хамгаалалтын талаарх тоо хэмжээ, байршлыг эцэслэн тодорхойлов.

Шинээр баригдах химийн лабораторын барилгыг ундны цэвэр усаар хангах, агааржуулалт, бохир усны трасс болон дулаан хангамжийн шийдлийг станцын зүгээс “Икон Консалтинг” ХХК-д хүргэж зурагт тусгуулав. Мөн түүхий усны барилгын байршлыг тодотгох зорилгоор 10000 бакны ард 4 метр

орчим ухааж, шугамыг ил гарган хэмжилтийг хийлгэж зурагт тусгаснаа баталгаажуулсан. Түүхий усны насос станцын барилгын галын усны шугам хоолой, дулаан хангамж, дренажийн системийн шийдлийг гарган тохирч холбох цэгүүдийг бүрэн тодорхойлов. Түүхий усны насос станцаас Турбин цех хүртэлх шинээр татагдах Ø400 мм-ын хос 2 шугамын трассыг стакад дээгүүр явуулахтай холбоотой нарийвчилсан хэмжилтүүдийг хийж зурагт тусгуулсан. Түүхий усны насос станцын усны схем болон хэмжих хэрэгслүүдийн тоо хэмжээ, цэвэрлэгдсэн усны шугамд тавигдах тоолуур, хэмжих хэрэгсэл тоо хэмжээ болон байрлуулах байрлал, ДУТШ-1,2-т байрлах сервер болон компьютер удирдлагын хяналтын системийн талаарх байрлал, бусад шийдлийн талаар төслийн зөвлөхтэй хамтран ажиллав.

ХЦ-ийн ИТА-уудад MCS Интернэйшнл ХХК-ийн төслийн инженерүүд, Казакстан улсын Фалко компанийн мэргэжилтэнгээс бодис дозлох талаарх танилцуулга уулзалтыг 2023 оны 10 дугаар сарын 06-нд зохион байгуулав.

Ус дахин боловсруулах төслийн хүрээнд хийгдэх ажлаар олон улсын нээлттэй тендерийг МСК, ММСС-аас 2023 оны 01 дүгээр сарын 06-нд зарлаж, гадаад дотоодын компаниудад тендерийн материал хүргүүлсний дагуу Турк, Чех, Хятад болон Монгол улсын нийт 19 компанийн 54 төлөөлөгч 2023 оны 02 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд компани дээр хийгдэх ажлуудтай танилцах ажлын байрны уулзалт, танилцуулах ажлыг ММСС-ынхантай хамтран зохион байгуулсан.

Олон улсын нээлттэй тендерт Швейцарийн нэг, Монгол улсаас 2 компани оролцохоор материал ирүүлсэнг ММСС болон АНУ-ын МСК-аас томилогдсон тендерийн үнэлгээний хороо хянаж, шалган гүйцэтгэгчийг шалгаруулсан. Ерөнхий гүйцэтгэгчээр Монгол улсын “MCS Интернэйшнл” ХХК шалгарч ажил гүйцэтгэх гэрээгээ баталгаажуулан 2023 оны 8 дугаар сарын 25-нд ажил эхлүүлсэн.

ЗУУХ №5-8-ЫН МҮМ-21FL ТЭЭРМИЙН БУЛНЫ РОЛИК, ТАВАГ БА ХЯНАЛТ УДИРДЛАГЫН СИСТЕМ ШИНЭЧЛЭХ АЖИЛ

Төслийн өгөгдлөөр Зуух №5-8-ын булны роликтэй элэгдэл 50 мм, тавгийн элэгдэл 30 мм болоход шинээр солих шаардлагатай. 2021 онд булны ролик, тавагны элэгдлийг үйлдвэрлэгчийн зөвлөмжийн дагуу хэмжиж судлахад 30'000 – 35'000 ажиллагааны цагийн дараа буюу 2023 онд Зуух №5 (одоогийн байдлаар 34'000 цаг) болон №7 (одоогийн байдлаар 31'000 цаг), 2024 онд Зуух №6 (одоогийн байдлаар 24'000 цаг) болон Зуух №8 (одоогийн байдлаар 30'000 цаг)–ын бул тавагны элэгдэл солих хэмжээнд тус тус хүрч байна. Үйлдвэрлэх хугацаа уртаас шалтгаалан бул тавгийг нийлүүлэх Японы Иточу компанитай гэрээ байгуулахаар ажиллаж байна. 2 зууханд шаардлагатай хөрөнгийн хэмжээ 5 тэрбум 480 сая төгрөг болно.



Д Х Х А Ц – и й н инженерүүд ба Япон улсын Yokogawa компани й инженерийн багтай хамтран 2024 онд зуны бага ачаалалд Зуух № 5-8-ыг үе шаттайгаар зогсоож

хяналт удирдлагын DCS систем FCS/CPU/AFG30D шинэ загварын CP-471 болон шинэ сүлжээний хувиргагч сүлжээ кабель татах, шинээр шкаф суурилуулахаар гэрээ байгуулсан. Төслийн ажлыг эхлүүлээд байна. Энэ төслийн зардал 1,6 сая америк доллар буюу 5 тэрбум 496 сая төгрөг болж байна.

Дээрх төслүүдийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлж, 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

ТЗБАХ-ЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны компанийн бизнес төлөвлөгөөнд тодотголоор ТЗБАХ–ээр 1 ажил хэрэгжүүлэхээр тусгасан. “BT №1-4 трансформатуудад тоолуур суурилуулах” ажлын тендер зарлан гүйцэтгэгчийг шалгаруулсан. “Гуа–Орд” ХХК-тай гэрээ байгуулж, суурилуулалтын ажлыг гүйцэтгэсэн. Технологийн горим ажиллагаатай холбоотой өвлийн их ачааллын дараа холболтын ажлыг хийж гүйцэтгэнэ.



КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ, Эрчим хүчний системд эзлэх байр суурь

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын зөвлөл

08

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот тувшингийн биелэлт, Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай, Засварын ажлын талаар, Техник, технологийн шинэчлэл, төсөл

12

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

20

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын санал, дүгнэлт, Аудитлагдсан санхүүгийн тайлан, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн чадавхийн шинжилгээ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд, Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр

47

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

Хүний нөөц, Ил тод, ёс зүйн байдал, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

41

31

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар, Санхүүгийн дотоод аудит, MNS ISO9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт, Тарифын зохицуулалт, Эрчим хүчний ах үүсвэрүүдийн 2023 оны үнийн судалгаа



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.25 № 071819
танай _____-ны № _____-т

ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ү.ТӨМӨРХУЯГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дулааны IV цахилгаан станц ТӨХК-ийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 13,895.7 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Тайлант оны эцсийн байдлаар 9 харилцагчтай холбоотой 137.3 сая төгрөгийн өглөг, 31 харилцагчтай холбоотой 281.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа нэг компанид давуу эрх олгож 7 удаагийн 7,176.6 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан ба тендерт оролцогчийн ажиллах хүчин, хүний нөөцийн хүчин чадлын мэдээллүүд нь эдгээр ажлуудыг нэгэн зэрэг гүйцэтгэх нөөц боломжгүй байхад сонгон шалгаруулсан ба энэ нь 4,836.3 сая төгрөгийн 3 гэрээт ажлыг хугацаа хоцроож гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлсэн;
- Нийт 6 төсөл, арга хэмжээний 1,361.1 сая төгрөгийн гэрээг байгуулахдаа 40.8 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргуулан аваагүй буюу гэрээ байгуулах эрх үүсээгүй байхад хууль зөрчиж гэрээ байгуулсан;

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

- Худалдан авах ажиллагааны тайланг дутуу, алдаатай бэлтгэж ирүүлсэн, тендерийн материалыг хуулийн шаардлагад нийцүүлэн тендерийн баримт бичигт заавал хавсаргах баримт бичгийг иж бүрнээр нь хавсаргаагүй;
 - Бараа материалын дансанд 5 буюу түүнээс дээш жилийн хугацаанд ашиглагдаагүй 789 нэр төрлийн 3,171.8 сая төгрөгийн насжилт өндөртэй бараа материалын нөөц үүсгэсэн
- зэрэг зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: ... 5.1.4 Үнэн зөв байх; ...", ТБОНӨХБАҮХАТ хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 43 дугаар зүйлийн 43.4-т "Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана: ... 43.4.1. 150 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй ажил худалдан авах гэрээ байгуулах; 43.4.2. 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах; 43.4.3. хоёр жилээс дээш хугацаагаар үргэлжлэх худалдан авах гэрээ байгуулах; ...", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:... 15.1.6 нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх; ..." гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Хөгжлийн банктай байгуулсан Турбоагрегат №1-4-н төслийн шинэчлэлийн 70,638,904.91 еврогийн зээлийг төгрөгт шилжүүлэн, хугацааг 3 жилээр сунгасан нь тус компанийн богино хугацаат өр төлбөрийг бууруулж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт зэрэг нөлөө үзүүлсэн байна. 2024 оноос хугацаа хэтэрсэн зээлд тооцох нэмэгдүүлсэн хүү, валютын ханшийн зөрүү үүсэхгүй нь компанийн санхүүгийн үзүүлэлтэд ач холбогдолтой болсон байна.

Цахилгаан станц нь 1 сая м.куб дэгдэмхий үнс ба шлакны холимгийг 3-4 жилийн хугацаанд ялгаруулдаг бөгөөд мөн ийм давтамжтай үнс хадгалах байгууламж шинээр бий болгох шаардлагатай тул энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор 1,650,000 м3 эзлэхүүн бүхий үнсэн сангийн карт №2 ажлыг гүйцэтгэсэн нь ДЦС-4-ын үндсэн тоноглолын тасралтгүй найдвартай ажиллах нөхцөлийг бүрдүүлжээ.

Аудитын гол асуудал

Тус компани нь 466,702.2 сая төгрөгийн хуримтлагдсан өр төлбөрийн үлдэгдэлтэй, урт хугацаат зээлийн эргэн төлөлт хийгдэхгүй байгаа нь Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгаан, дулааны борлуулалтын үнэ тарифыг өртгөөс нь бага үнээр тогтоож ирсэнтэй холбоотой ба үүнээс шалтгаалж компанийн ашигт ажиллагаа болон тасралтгүй үйл ажиллагаанд эрсдэл үүсэхээр байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн үйл ажиллагааны тайланд 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 7 бүлэг 24 ажил төлөвлөснөөс биелэлт нь 99.9 хувь, чанарын зорилтын хүрээнд 7 ажил төлөвлөж 100.0 хувийн биелэлттэй, компанийн эрсдэлийн төлөвлөгөөнд

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

10 хэсэгт 160 ажил төлөвлөснөөс 93.5 хувийн биелэлттэй, 2023 онд нийт 2144 аюул мэдээлэгдсэний 1944 аюул буюу 90.8 хувийг арилгасан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/мянган төгрөг/

	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
Хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,888,802.9	14,066,309.3
Дансны авлага	19,604,250.1	22,049,014.1
Бараа материал	29,111,125.9	29,642,429.6
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	6,629,612.3	6,358,272.4
Үндсэн хөрөнгө	872,114,260.8	843,456,526.9
Биет бус хөрөнгө	76,937,241.6	77,047,166.8
Бусад эргэлтийн бус хөрөнгө	514,389.3	1,092,304.5
Нийт хөрөнгө	1,010,799,682.9	993,712,023.5
Өр төлбөр		
Дансны өглөг	1,692,407.0	1,885,660.5
Цалингийн өглөг	5,298,260.4	6,801,086.6
Татвар, НДШ-ийн өр	1,009,935.0	5,581,471.9
УХ-т зээлийн тайлант үеийн өглөг	143,091,087.4	17,636,287.2
Хүүгийн өглөг	818,874.8	791,402.6
Нөөц өр төлбөр /БХ-т/	1,146,722.4	1,000,301.5
Урьдчилж орсон орлого	1,003,819.6	4,087,902.7
Бусад богино хугацаат өр	845,606.9	1,465,850.5
Урт хугацаат зээл	289,995,706.3	390,116,249.8
Нөөц өр төлбөр /УХ-т/	13,059,122.8	13,018,062.0
Хойшлогдсон татварын өр	8,356,560.9	7,305,387.0
Хойшлогдсон орлого	17,926,910.2	17,012,543.7
Нийт өр төлбөр	484,245,013.7	427,452,242.6
Эзэмшигчийн өмч		
Төрийн өмч	227,071,740.0	227,071,740.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	257,661,148.8	257,661,148.8
Эздийн өмчийн бусад хэсэг	78,008,219.9	78,008,219.9
Хуримтлагдсан ашиг / алдагдал/	-36,186,439.5	-35,731,291.6
Эздийн өмчийн дүн	526,554,669.2	527,009,817.3
Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн	1,010,799,682.9	993,712,023.5

ОРЛОГЫН ТАЙЛАН

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
1	Борлуулалтын орлого /цэвэр/	319,326,128.2	430,276,928.7
2	Борлуулалтын өртөг	324,811,782.6	408,996,784.3
3	Нийт ашиг /алдагдал/	-5,485,654.4	21,280,141.4
4	Түрээсийн орлого	173,163.2	192,278.6
5	Хүүний орлого		148,770.1
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	11,936,390.6	5,639,898.0
9	Борлуулалт, маркетингийн зардал	2,661,113.9	2,705,543.3
10	Ерөнхий удирдлагын зардал	4,722,963.2	6,507,216.9
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	9,632,898.0	10,128,440.9
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	-39,583,806.9	-2,286,387.0
14	Үндсэн хөрөнгө данснаас хассан олз /гарз/	77,912.8	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/		
17	Бусад ашиг /алдагдал/		43,584.8
18	Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/	-50,054,795.4	5,677,084.8
19	Орлогын татварын зардал	354,793.2	4,515,174.9
20	Татварын дараах ашиг /алдагдал/	-50,409,588.6	1,161,909.8
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-50,409,588.6	1,161,909.8
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз /гарз/		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/		

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	227,071,740.0	311,515,695.2	78,008,219.9	-31,229,114.6	476,659,959.7
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-4,063,558.2	-4,063,558.2
3	Залруулсан үлдэгдэл					
4	Тайлант үеийн цэвэр ашиг				-50,409,588.6	-50,409,588.6
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт					
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		-53,854,546.4			-53,854,546.4
9	2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	227,071,740.0	257,661,148.8	78,008,219.9	-36,186,439.6	526,554,669.2
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-706,761.8	-706,761.8
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг				1,161,909.8	1,161,909.8
13	Бусад дэлгэрэнгүй орлого					
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	227,071,740.0	257,661,148.8	78,008,219.9	-35,731,291.6	527,009,817.2

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
1.1	Мөнгөн орлогын дүн +/-	315,579,289.6	406,770,690.2
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	313,025,288.9	404,445,333.7
	Бусад мөнгөн орлого	2,554,000.7	2,325,356.5
1.2	Мөнгөн зарлагын дүн +/-	311,680,122.1	376,335,551.6
	Ажиллагчдад төлсөн	41,062,094.8	50,475,918.1
	НД-ийн байгууллагад төлсөн	14,191,558.2	16,606,078.0
	Бараа материал худалдан авахад төлсөн	142,172,303.8	184,700,000.0
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэл төлсөн	52,181,388.8	55,802,060.8
	Хүүний төлбөр төлсөн	16,770,121.8	12,662,759.9
	Татварын байгууллагад төлсөн	17,228,338.6	15,017,202.1
	Даатгалын төлбөрт төлсөн	98,524.7	65,469.4
	Бусад мөнгөн зарлага	27,975,791.3	41,006,063.3
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,899,167.5	30,435,138.6
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
2.1	Мөнгөн орлогын дүн +/-		148,770.1
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Хүлээн авсан хүүгийн орлого		148,770.1
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн +/-	4,851,440.9	2,092,808.8
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,995,323.1	2,092,808.8
	Бусад урт хугацаат хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн	2,856,117.8	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-4,851,440.9	-1,944,038.7
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
3.1	Мөнгөн орлогын дүн +/-	2,874,876.1	
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	2,874,876.1	
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.2	Мөнгөн зарлагын дүн +/-	5,079,530.9	20,054,746.5
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	1,513,610.9	20,054,746.5
	Төлсөн ногдол ашиг	3,565,920.0	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-2,204,654.9	-20,054,746.5
3.4	Валютын ханшийн зөрүү		-258,847.1
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-3,156,928.2	8,177,506.4
5	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,045,731.2	5,888,802.9
6	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,888,802.9	14,066,309.3

САНХҮҮГИЙН ЧАДАВХИЙН ШИНЖИЛГЭЭ

1. Төлбөрийн чадварын шинжилгээ

	Үзүүлэлтүүд	Харьцаа	2022.12.31	2023.12.31	Өмнөх онтой харьцуулахад
1.1	Цэвэр эргэлтийн хөрөнгө	Нийт ЭХ - БХӨТ	-93,672.9	32,866.1	126,539.00
1.2	Үнэмлэхүй хөрвөх хөрөнгийн харьцаа	МХ+ТБҮЦ / БХӨТ	0.04	0.36	0.32
1.3	Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа	МХ+ТБҮЦ+Авлага / БХӨТ	0.16	0.92	0.76
1.4	Эргэлтийн харьцаа	Нийт ЭХ / БХӨТ	0.40	1.84	1.44
1.5	Эргэлтийн хөрөнгийн хувийн жин	Нийт ЭХ / Балансын цэвэр дүн	0.06	0.07	0.01
1.6	Цэвэр эргэлтийн хөрөнгийн хувийн жин	Цэвэр ЭХ / Нийт ЭХ	-1.53	0.46	1.99
1.7	Он дамжсан болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийн хувийн жин	Хугацаа хэтэрсэн ӨТ / Нийт өр төлбөр	0.02	0.04	-0.26

2. Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ

	Үзүүлэлтүүд	Харьцаа	2022.12.31	2023.12.31	Өмнөх онтой харьцуулахад
2.1	Бие даах чадварын коэффициент	Өөрийн капитал / Балансын цэвэр дүн	0.52	0.53	0.01
2.2	Санхүүгийн хамаарлын коэффициент	Балансын цэвэр дүн / өөрийн капитал	1.92	1.89	-0.03
2.3	Зохицуулалтын коэффициент	Өөрийн эргэлтийн капитал / өөрийн капитал	-0.18	0.06	0.24
2.4	Гадны капиталын хувийн жин	Гадны капитал / Нийт капитал (Балансын пассивын дүн)	0.33	0.43	0.10
2.5	Урт хугацаат зээл болон өөрийн капиталын харьцаа	урт хугацаат зээл / өөрийн капитал	0.63	0.81	0.19
2.6	Гадны ба өөрийн капиталын харьцаа	Гадны капитал / өөрийн капитал	0.92	0.89	-0.03
2.7	Төлбөрийн хэтийн боломжийн үзүүлэлтүүд				
2.7a	Хүү төлөх чадвар	Хүү + ТӨЦА / Хүүгийн зардал	-2.81	1.39	4.19
2.7b	Хүү ба үндсэн өрийг төлөх чадвар	Хүү + ТӨЦА + байгуулсан ҮХЭХШ / Хүүгийн зардал + Үндсэн өр	0.05	0.18	0.13
2.7c	Альтманы индекс	$3.3k1 + 1.0k2 + 0.6k3 + 1.4k4 + 1.2k5$	0.97	1.29	0.31
	K1	хүү + ТӨЦА / Нийт хөрөнгө	-0.04	0.02	0.06
	K2	Борлуулалтын орлого / Нийт хөр	0.32	0.43	0.12
	K3	Өөрийн кап / Гадны капитал	1.60	1.23	-0.37
	K4	Ногдол ашиг төлсний дараахь цэвэр ашиг / нийт хөрөнгө	-0.05	0.01	0.06
	K5	Өөрийн эргэлтийн капитал / Нийт хөрөнгө	-0.09	0.03	0.13

3. Эргэцийн шинжилгээ

	Үзүүлэлтүүд	Харьцаа	2022.12.31	2023.12.31	Өмнөх онтой харьцуулахад
3.1	Авлагын эргэц (удаа)	Бор.ор / Авлагын дундаж үлдэгдэл	12.42	15.98	3.56
3.2	Авлагын эргэц (өдөр)	360 хоног / Авлагын эргэц (удаа)	28.98	22.53	-6.45
3.3	Нөөцийн эргэц (удаа)	ББӨ / БМҮБЗ дундаж өртөг	13.40	13.92	0.52
3.4	Нөөцийн эргэц (өдөр)	360 хоног / Нөөцийн эргэц (удаа)	26.98	25.86	-1.01
3.5	Эргэлтийн хөрөнгийн эргэц (удаа)	Бор орлого / ЭХ дундаж үлдэгдэл	5.19	6.45	1.27
3.6	Эргэлтийн хөрөнгийн эргэц (өдөр)	360 хоног / ЭХ-н эргэц (удаа)	69.40	55.78	-13.61
3.7	Нийт хөрөнгийн ачаалалт	Бор.ор / Бал.цэвэр дүн	0.32	0.43	0.12
3.8	Өглөгийн эргэц (удаа)	Зээл.Худ ав / Өг.дундаж үлдэгдэл	1.20	0.40	-0.80
3.9	Өглөгийн эргэц (өдөр)	360 хоног / Өглөгийн эргэц (удаа)	298.89	890.40	591.52
3.10	Үйлдвэрлэлийн циклийн хугацаа	Ав.эргэц (өдөр) + Нөөцийн эргэц (өдөр)	55.85	48.39	-7.46
3.11	Санхүүгийн циклийн хугацаа	Ав.эргэц (өдөр) + Нөөцийн эргэц (өдөр) - Өглөг эргэц (өдөр)	-243.04	-842.02	-598.98

4. Бүтээмжийн шинжилгээ

	Үзүүлэлтүүд	Харьцаа	2022.12.31	2023.12.31	Өмнөх онтой харьцуулахад
4.1	Хөдөлмөрийн бүтээмж	Бор.ор / Аж.дын дансны дундаж тоо	214.89	289.36	73.60
4.2	Үндсэн хөрөнгийн ачаалал	Бор.ор / Үнд.хөр.дундаж өртөг	0.77	1.05	0.68
4.3	Материал өгөөж	Бор.ор / БМҮБЗ дундаж өртөг	16.44	28.52	17.65
4.4	Эдийн засгийн тогтвортой өсөлтийн коэффициент	Цэвэр ашиг - Төлсөн ногдол ашиг / Өөрийн капитал	-0.10	0.00	0.10

5. Үндсэн хөрөнгийн шинжилгээ

	Үзүүлэлтүүд	Харьцаа	2022.12.31	2023.12.31	Өмнөх онтой харьцуулахад
5.1	Үндсэн хөрөнгийн хувийн жин	Нийт ҮХ-н өртөг / Балансын цэвэр дүн	0.86	0.85	-0.01
5.2	ҮХ-н нийт дүнд үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн эзлэх хувийн жин	Үйлдвэрлэлийн зориулалттай ҮХ / Нийт ҮХ-н өртөг	0.79	0.79	0.00
5.3	Үндсэн хөрөнгийн элэгдлийн коэффициент	ҮХ-н хур элэгдэл / ҮХ-н балансын өртөг	0.47	0.50	0.03
5.4	ҮХ-н шинэчлэлтийн коэффициент	Тайлант хугацаанд шинээр ашиглалтанд орсон ҮХ-н анхны өртөг / Тайлант хугацааны эцэст байсан ҮХ-н анхны өртөг	0.00	0.00	0.00
5.5	ҮХ-н хасагдалтын коэффициент	Тайлант хугацаанд ашиглалтаас хасагдсан ҮХ-н анхны өртөг / Тайлант хугацааны эхэнд байсан ҮХ-н анхны өртөг	0.00	0.00	0.00

6. Ашигт ажиллагааны шинжилгээ

	Үзүүлэлтүүд	Харьцаа	2022.12.31	2023.12.31	Өмнөх онтой харьцуулахад
6.1	Борлуулалтын ашигт ажиллагаа	Үндсэн ажиллагааны цэвэр орлого / Борлуулалтын орлого	-0.02	0.05	0.07
6.2	Өртгөөр тооцсон борлуулалтын ашигт ажиллагаа	Үндсэн ажиллагааны цэвэр орлого / Борлуулалтын бүт.өртөг	-0.02	0.05	0.07
6.3	Хөрөнгийн ашигт ажиллагаа	Цэвэр ашиг / Балансын цэвэр дүн	-0.05	0.01	0.06
6.4	Өөрийн капиталын ашигт ажиллагаа	Цэвэр ашиг / Өөрийн капитал	-0.10	0.01	0.11

7. Мөнгөн урсгалын шинжилгээ

	Үзүүлэлтүүд	Харьцаа	2022.12.31	2023.12.31	Өмнөх онтой харьцуулахад
7.1	Мөнгөн орлого ба борлуулалтын харьцаа	Үйл ажиллагааны мөнгөн орлого / Борлуулалтын орлого	0.99	0.73	-0.25
7.2	Мөнгөн орлого ба хөрөнгийн харьцаа	Үйл ажиллагааны мөнгөн орлого / Балансын цэвэр дүн	0.31	0.32	0.01
7.3	Мөнгөн зарлага ба борлуулалтын харьцаа	Үйл ажиллаганы мөнгөн зарлага / Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.01	0.01	0.00

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ, Эрчим хүчний системд эзлэх байр суурь

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын зөвлөл

08

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот туашингийн биелэлт, Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай, Засварын ажлын талаар, Техник, технологийн шинэчлэл, төсөл

12

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

20

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын санал, дүгнэлт, Аудитлагдсан санхүүгийн тайлан, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн чадавхийн шинжилгээ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд, Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр

47

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

Хүний нөөц, Ил тод, ёс зүйн байдал, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

41

31

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар, Санхүүгийн дотоод аудит, MNS ISO9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт, Тарифын зохицуулалт, Эрчим хүчний эх үүсвэрүүдийн 2023 оны үнийн судалгаа

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

2023 онд үйлдвэрлэлийн осолгүй ажиллахад чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээнүүд:

Ослын тоо

2023 0

2022 2

2021 0

2020 0


2019 1

- 2023 онд ХЭМАБ-ын ISO 45001:2018 менежментийн тогтолцооны хэрэгжилтэд дотоод аудит хийх график, хөтөлбөр гарган арба, хэлтэс, цех нэгжүүдэд 1 удаа хийж 12 НҮТ (Ноцтой үл тохирол), 41 ЖҮТ (Жижиг үл тохирол), 45 А (Ажиглалт) өгч залруулах тайлан гаргаж ажлуудыг хийлгэсэн. Дотоод аудиторчуудын чадамжийг дээшлүүлэх зорилгоор 7 ажилтанг ОШМИ консалтинг ХХК сургалтанд хамруулсан.
- Ажилтан нарт нийт ажилтан нарын ХАБЭА-н сургалтыг 1114 ажилтанд гадны байгуулгаар хийлгэж нэн түрүүнд аюулгүй ажиллагаа гэдгийг ойлгуулсан. Мөн удирдлагын түвшинд ажил олгогчийн сургалтыг зохион байгуулж 20 удирдлага хамрагдсан. Хүн ахлан ажилладаг 48 ажилтан нарыг ХАБ-ын ажилтны мэргэшүүлэх сургалтанд хамруулж аюулгүй ажиллагааны ойлголт бүрэн өгсөн.
- Хөлсний гэрээгээр ажиллаж байгаа 50 ажилтан, мотоцикл, мопед, унадаг дугуй болон скүүтэр унаж ажилдаа ирж буцдаг 36 ажилтан нарт аюулгүй ажиллагааны сургалт хийж, зааварчилгаа өгсөн.
- Цехүүдэд хөдөлмөрийн аюулгүй байдлын "Пост"-ыг өдөр бүр инженер техникийн ажилтнууд ээлжлэн хийж хэвшсэн.
- 2023 онд Гүйцэтгэх захирал, Ерөнхий инженер нарт аюулгүй ажиллагаатай холбоотой 11 илтгэх хуудас, мэдэгдэл, албан шаардлага хүргүүлж нэгж хэсгүүдэд тараан хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.

- 2023 оны хэсэгчилсэн зогсолтоор Хяналтын албаны бүх инженерүүд хөдөлмөрийн, техникийн, галын аюулгүй байдлыг хангуулах чиглэлд хяналт тавин ажилласан.
- Хяналтын албаны даргын нэрэмжит ХАБ-ын инженерүүд нэгдсэн баг цехүүдээр үзлэг, шалгалтаар явах графикайн дагуу сар бүр ээлжит бус байдлаар үйлдвэрийн ажлын байруудад үзлэг шалгалт хийж хэвшсэн. Аюултай 62 зөрчлийг илрүүлж, арилгасан.
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.5-д заасны дагуу "Мөнх чандмань хүрд" ХХК нь "Дулааны цахилган станц-4" ТӨХК -ийн 18 ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2023 оны 09 сарын 18-27-ны өдрүүдэд гүйцэтгэж тайлангийн дагуу авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан.
- Эрчим хүчний яамнаас ирүүлсэн "Осол мэдээллийн даалгавар"-ын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө 2 удаа бэлтгэж биелэлтийг ханган ажилласан.
- Гэрээгээр ажил гүйцэтгэсэн 20 гадны байгуулгад ажил гүйцэтгэх Ерөнхий зөвшөөрөл өгч 3 аж ахуйн нэгжид хөдөлмөрийн аюулгүй байдлыг ханган ажиллах тухай "Албан шаардлага"-ыг өгч шаардлагын биелэлтийг хангуулан ажилласан.
- Гүйцэтгэх захирлын баталсан удирдамжийн дагуу улирал бүр хөдөлмөрийн аюулгүй байдлын III шатны үзлэгийг станцын бүх цех, нэгжид явуулж, 96 зөрчлийг илрүүлэн арилгасан.
- Ажилтан нарыг ХАБЭА-н чиглэлээр манлайлагч байлгах зорилгоор Энх-Оршихуй уралдааны зохиож цех, нэгж, хувь хүнээр шалгаруулж манлайлагч нарт урамшуулал олгодог. Мөн цех, нэгжүүд дотооддоо эрүүл аюулгүй орчин нэртэй ХАБ-ын тэмцээн зохион байгуулж ХАБЭА-г сурталчлан таниулж урашуулж ажилладаг.

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах чиглэлд хийгдсэн ажлууд:

Ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийн үзүүлэлт /Станцын дундаж/



1. Ажлын байрны гэрэлтүүлэг сайжруулах чиглэлд хийгдсэн ажлууд:

2023 оны урсгал засвараар 28 ажил төлөвлөн, гүйцэтгэсэн. Томоохон ажлуудаас дурдвал:

- Түлш дамжуулах цехийн ЛК-4 ажлын орчны гэрлийг бүрэн сольж сайжруулж стандартад хүргэх.
- Зуухан заалны зүүн хана дагасан орчмыг гэрэлтүүлэг лед гэрэлтүүлэгээр шинэчлэх
- К1-8 гадна үнсний бункер орчмын гэрэлтүүлгийн сүлжээг бүрэн шинэчилж лед гэрэлтүүлгээр солих
- Хими цехий давсны уусмал бэлтгэх заалны гэрэлтүүлгийн бүрхүүлийг лед гэрлээр бүрэн солих
- Сонгино насос станцын заалны гэрэлтүүлэг шинэчлэх
- Коллектор станц №1,2 заалны гэрэлтүүлэг лед гэрлээр солих
- Механик цехийн тросс сүлжих байрны гэрэлтүүлэг бүрэн шинэчилж солих

Ажлын байрны халуун бууруулах чиглэлд :

- 2023 онд дулаан алдагдалтай

Бусад сургалтын талаар:

№	Сургалтын нэр	Хамрагдсан ажилтны тоо	Тайлбар
1	ХАБ-ын мэргэшсэн мэргэжилтний сургалт	3	МАОЭНХолбооноос зохион байгуулсан сургалтанд ажилттай хамрагдаж дүүргэсэн.
2	“Нэн түрүүнд ХАБ” бага хурал	2	Удирдлага – 1 ИТА – 1

тоноглолуудад үзлэг хийж дулаалга хийх шаардлагыг нэгжүүдэд хүргүүлсэн. Халуунтай холбоотой аюулгүй ажиллагааны зөвлөмж гаргаж ажилтан нарт тараасан.

- Тэмдэгт 31.000-д байрлах приточный вентиляторуудыг тогтмол ажиллагаанд байлгах, ажиллагаанд нь тогтмол хяналт тавьж ажилласан.
- Ажлын болон ахуйн байрнуудад эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх талаар цех нэгжүүдийн болзолт уралдаан, төлөвлөгөөт ажлуудын хүрээнд станцын хэмжээнд 91 ажлыг хийж гүйцэтгэсэн.

ХАБЭА-н удирдлагын тогтолцооны тогтолцооны хүрээнд хийгдсэн ажил:

- ISO 45001:2018 менежментийн тогтолцооны хүрээнд ХЭМАБ-ын бодлого, хамрах хүрээ болон үйл явцыг бүрэн тодорхойлж гаргасан. Стандартын дагалдуулан эрсдэлийн менежментийн журам боловсруулж мөрдөн ажиллаж байна. ISO 45001:2018 стандартын дотоод аудит хийх хөтөлбөр жилд 2 удаа нэг нэгжид хийхээр гарсан. Бид 2022 оны 11 дүгээр сараас 2023 оны 6 сар хүртэл буюу хагас жилийн хугацаанд 1 удаа хийсэн.

Сургалт, шалгалт


- ХАБЭА-н тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 17.3, 17.4, Эрчим хүчний ажилтны дунд зохиох аюулгүй ажиллагааны ажлын үндсэн дүрмийн 11 дүгээр заалтын дагуу 2023 оны 01 сарын 23-27 өдрийн хооронд ХАБЭА-н нийт ажилтны сургалтыг Станцын ҮЭ-ийн хороотой хамтран МҮЭХ-ны “ХӨДӨЛМӨР” сургалт, судалгааны төвөөр тусгай хөтөлбөрийн дагуу ҮА, ТДЦ, ЗЦ, ТЦ, ЦЦ, ДХХА, ХЦ, МЦ-ийн нийт 914 ажилтан нарт дараах сэдвээр сургалтыг зохион байгуулсан. ХАБЭА-н удирдлагын тогтолцоо сайжруулах хүрээнд ИТА нарт явуулсан сургалтад 200 ажилтан хамрагдсан байна.

3	ХАБ-ын ажилтныг мэргэшүүлэх сургалт	48	МҮЭ холбооны дэргэдэх хөдөлмөр сургалтын төв, ХАБ академи, Ололт амжилтын түлхүүр зэрэг сургалтын төвтэй гэрээ байгуулж зохион байгуулсан.
4	МОШПА-ийн туршлага солилцох сургалт	5	Эрдэнэт хотын уулын баяжуулах үйлдвэр, станц, Ачит-Ихт ХХК нараар орж сайн туршлага судалсан.
5	Хөдөлмөрийн эрүүл ахуйчдын холбооноос зохион байгуулсан "Ахисан түвшний хөдөлмөрийн эрүүл ахуй" мэргэшүүлэх эрчимжүүлсэн сургалт	4	Танхимаар ажлын 5 өдөр хийгдсэн.
6	Анхны тусламж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, МШӨ / Венийн судасны өргөсөл/ түүнээс сэргийлэх нь сэдэвт сургалт	57	ЭЗЦГ-н ажилтан нарт анхны тусламж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого МШӨ / Венийн судасны өргөсөл/ түүнээс сэргийлэх нь сэдвээр сургалтыг тус тус хийсэн.
7	Цахилгааны ААД-ийн III-р групп олгох сургалт	9	ЗЦ, МЦ-ийн ӨЗМ цахилгааны засварчдад ААД-ийн группын сургалт хийж шалгалт авсан. Цахилгаан цехтэй хамтран сургалт зохион байгуулсан
8	ISO 45001:2018 стандартын дотоод аудиторын сургалт	7	ОШМИ консталтинг ХХК сургалтанд 4, 10 сард хамруулж баталгаажсан.
9	Онцгой байдлын үеийн дайчилгааны бие бүрэлдэхүүн болон гал унтраах бие бүрэлдэхүүний тактикийн сургалт	22	10 дугаар сарын 10 өдөр НОБГ-аас зохион байгуулж ХА-наас зохион байгуулалтанд дэмжлэг үзүүлж нийт ИТА нар оролцсон.
10	Хөлсний гэрээгээр ажиллаж байгаа ажилтан нарт хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт	50	Сургалтын хөтөлбөр гаргаж 5 бүлэг сэдвээр сургалт хийж, шалгалт авсан.
11	ISO45001:2018 стандартын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэлтийг сайжруулах сургалт	200	Нэгжийн удирдлага, ИТА нарт ISO45001:2018 стандартын тэргүүлэх аудитор, доктрант Г.Эрдэнэтөгс багштай гэрээ байгуулж Дөл танхимд хийсэн. 2023 оны 6-р сарын 18-25 өдөр
12	Ажил олгогчийн сургалт	20	МАОЭНХолбоотой гэрээ байгуулж 11-р сарын 24 өдөр зохион байгуулж Ерөнхий инженер тэргүүтэй удирдлагын баг гадуур хамрагдсан.
13	Мотоцикл, мопед, унадаг дугуй болон скүүтэр унаж ажилдаа ирж буцдаг ажилтнуудын сургалт	36	ДӨЛ танхимд цуглуулж аюул эрсдэлийн талаар сургалт хийсэн.
Нийт		463	Гадны байгуулгаар төлбөртэй сургалтанд 282 ажилтан хамрагдаж, дотооддоо бусад сургалтыг 145 ажилтанд хийсэн.

Эрсдэлийн үнэлгээ

Аливаа ажлыг гүйцэтгэхийн өмнө түүний эрсдэлийг үнэлэх үнэлгээнд туссан аюулгүй ажиллах горимыг мөрдөж хэвшүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээ юм. Эрсдэлийг үнэлэх журмын дагуу 2023 онд ажлын байрны нөхцлийн эрсдэлийн үнэлгээ, ажил хийх үеийн эрсдэлийн үнэлгээг мөрдөж түүнд хяналт тавьж ажиллаж байна. Энэ онд

байгуулгын эрсдэл өндөр 17 ажлын жагсаалтыг гаргаж ажлын хэсэг байгуулж ажлын байраар үзлэг хийж эрсдэлийг үнэлэж эрсдэл бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд оруулж ажилласан. Гүйцэтгэл- 88,5% гүйцэтгэлтэй гарч байна. Цехүүд дээрх эрсдэлийн үнэлгээг шинэчлэх, сайжруулах ажил хийгдэж байна. Одоогоор 128 эрсдэлийн үнэлгээ шинэчилсэн.



Аюулыг мэдээлэх хуудас

2023 оны 11 сарын байдлаар нийт "АМХ"-аар 2144 аюул мэдээлэгдсэн. Үүнээс 90,8% буюу 1944 аюулыг устгах арга хэмжээ авсан байна. Энэ нь 150 удаагийн эд хөрөнгийн хохирол гарах, 50 удаагийн эмнэлгийн анхны тусламж авах хэмжээний гэмтэл, 5 удаагийн хүний амь нас эрсдэх үр дагавартай аюултай тохиолдлоос сэргийлж чадсан гэж үзэхээр байна.

Ажлын байр болон ахуйн байруудад эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлэх, тохижилт гоо зүйг сайжруулах, ХАБЭА-г хангах, хөдөлмөр хөнгөвчлөхөөр хийгдсэн ажлуудаас дурьдвал:

- Зуух №3,7 их засвар, зуух №1,5 дунд засвар, Турбоагрегат №6 их засвар, турбоагрегат №7 дунд засвар хийж ажлын байрны эрсдэлийг бууруулсан.
- Засварт гарсан Зуухны УХ-4-р үеийн

нерж хэсгийн 900-ын булангийн маталтын радиусыг 150мм болгож томруулах, ханын зузааныг 6мм болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргуулсан. Мөн УХ-4 үеийн 12Х1МФ маркийн ключ булангуудын ханын зузааныг 6мм болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргасан. Энэхүү шийдвэрийн дагуу Зуух №6, зуух №7-ийн нийт 38ш пакетын булангийн маталт, хийцийг шинээр хийлгэж, хяналт тавьж зуух хагарч ажилтан халуун орчинд ажиллах нөхцлийг багасаж ажлын байрны эрсдэлийг бууруулсан

- Ажилтан нарын ХЭМАБ-н мэдлэгийг нэмэгдүүлж дүрэм журмын биелэлтийг хангуулах, хөдөлмөрийн болон технологийн зөрчилгүй ажиллуулах зорилгоор гарын авлагыг шинээр сайжруулж хэвлэлтэнд өгсөн.
- Өндөрт ажиллах үеийн аюулыг таниулах, өндрийн бүсийг бүрэн зөв зүүснийг шалгах стэнд шинээр хийж ажилтан нарт практик сургалт хийж бүс буруу зүүснээс гарах эрсдэлийг бууруулсан.
- Хиймэл бодит ертөнцөд аюулыг таниж мэдрэх түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор VR төхөөрөмж авч түүнд эхний ээлжинд аюулыг таниулах 1 контент хийлгэж шинэ ажилтан нарт үзүүлж ойлголт өгч аюул, эрсдэлээс сэргийлэх алхам нээсэн.
- Шинээр ажилд орж байгаа болон дадлага сургуулилт хийх, цехийн үйл ажиллагаатай танилцахаар ирсэн гадны хүмүүст цехийн бүтэц зохион байгуулалт, тоног төхөөрөмжийн үүрэг зориулалт, аюулгүй ажиллагааны зааварчилгааг багтаасан видео шинээр хийж 3 хэл дээр орчуулж гаргасан.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТЫН ДОТООД АУДИТ

Санхүүгийн хяналтын дотоод аудитын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлд хяналт тавих

Гүйцэтгэх захирлын 2021 оны 03 сарын 1-ны өдрийн А/151 тоот тушаалаар компанийн мэдээллийг шилэн дансанд оруулах алба, нэгж, хэлтэс, албан тушаалтнуудыг томилсон. Тушаалын дагуу хуулийн хугацаанд шилэн дансанд мэдээллүүдийг оруулах явцад хяналт тавьж ажилласан.

- 2023 оны 1-р улирлын шилэн дансанд оруулах 14 төрлийн 21 мэдээллийг хуулийн хугацаанд буюу 2023 оны 4 сарын 7-ны дотор оруулж дууссан.
- 2022 оны санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг 2023 оны 4 сарын 25-ны дотор буюу хуулийн хугацаанд шилэн дансанд байршуулсан.
- 2023 оны 2-р улирлын шилэн дансанд оруулах 14 төрлийн мэдээллээс 42 мэдээллийг хуулийн хугацаанд оруулж дууссан.
- 2023 оны 3-р улирлын шилэн дансанд

оруулах 14 төрлийн 84 мэдээллийг хуулийн хугацаанд оруулж дууссан.

- 2023 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансанд оруулсан “Цалингаас бусад 5 сая төгрөгнөөс дээш мөнгөн хөрөнгийн орлого зарлагын гүйлгээ” мэдээллийг шалгаж, илэрсэн зөрчлүүдийг хариуцсан нягтлан бодогчид танилцуулж, дүгнэлтийг удирдлагад танилцуулсан.

2. Санхүү бүртгэлийн ERP программ нэвтрүүлэлт

Санхүүгийн программийн 3-р үе шат нэвтэрч байгаатай холбоотойгоор хөгжүүлэлтийг сайжруулах тал дээр ERP программын ажилтнууд болон СБХ-тэй хамтран ажиллаж байна. Тухайлбал:

- Ерөнхий дансны задаргаатай гүйлгээг автоматаар үүсдэг болгосон бөгөөд гүйлгээ балансын дүнтэй тулгаж, үүссэн алдааны шалтгааныг тодруулж, залруулуулахаар OD ERP программын ажилтанд өгсөн. Цаашид уг алдааг давтан гаргахгүй байх тал дээр зөвлөмжийг өгч, 2024 оны 1 сараас эхлэн ажил гүйлгээ нэг бүр автоматаар задаргаатай үүсч байхаар программын хөгжүүлэлтийг хийж дуусгах үүрэг өгсөн.

3. Санхүү бүртгэлд хяналт тавих

Санхүүгийн программ шинээр нэвтэрч байгаатай холбоотойгоор СБХ-ийн үйл ажиллагаанд хяналт тавихаас илүүтэйгээр санхүүгийн программын шинэчлэлтэд биечлэн оролцож, аливаа алдаа зөрчлүүдийг тухай бүрт нь залруулан ажилласан байна.

- 2022 оны жилийн эцсийн бараа материалын тооллогын хүрээнд цехүүдийн агуулахуудад байгаа бараа материалуудын тооллогын дүнг нэгтгэж, урьдчилсан дүнг комиссын хуралд танилцуулсан. Зуухан цехийн агуулахын бараа материалд тооллого хийж, тооллогын тооцоог бодож СБХ-т өгсөн.

- 2022 оны жилийн эцэс болон 2023 онуудын бараа материал болон үндсэн хөрөнгөтэй холбоотой хийгдсэн ажил гүйлгээнүүдийг гүйлгээ баланстай тулган шалгаж, үүсэн зөрүүг ERP болон СБХ-ийн хариуцсан ИТА нарт залруулах зөвлөмжийг өгсөн.

- 2022, 2023 онуудын задаргаагүй гүйлгээний жасаалтыг засварлан ерөнхий дансны тайланг гүйлгээ баланстай тулган шалгаж, үүссэн алдааг залруулж, 2022 оны

жилийн эцсийн гүйлгээ баланс болон ерөнхий дансны тайланг бэлтгэсэн.

- 2022 оны жилийн эцсийн ХАОАТ-ын тайлангийн тооцооллыг шалгаж, илэрсэн алдааг залруулах зөвлөмжийг СБХ-ийн хариуцсан нягтлан бодогчид өгсөн.

- 2023 оны 1-5 сарын цалин бодолтыг хүн тус бүрчлэн шалгаж, илэрсэн алдааг залруулах зөвлөмжийг СБХ-т өгсөн залруулсан. Мөн 2023 оны эхний 3 сарын байдлаар ээлжийн амралт авсан ажилтнуудын амралтын мөнгийг тооцоолсон тооцоололд хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар СБХ-т өгсөн.

- 2022 оны жилийн эцэс болон 2023 оны эхний хагас жилийн өндөр насны тэтгэмжийн актуар тооцооллыг хийж, СБХ-т хүлээлгэн өгсөн.

- 2023 оны 1-4 саруудын касс болон харилцахын баримтуудын анхан шатны баримтуудын бүрдүүлэлтэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

- 2023 оны 2 болон 3-р улирлын байдлаар үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг шалгасан бөгөөд ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй.

- 2023 оны 2-р улирлын байдлаар борлуулалтын орлого болон НӨАТ-ын тооцооллыг шалгаж, илэрсэн алдааны жагсаалтыг СБХ-ийн ахлах нягтлан бодогчид залруулах зөвлөмжийн хамт өгсөн.

- Үндсэн хөрөнгийн татварын зорилгоорх хөрөнгийн үлдэгдэл, үндсэн хөрөнгө тус бүрийн дахин үнэлгээ болон 2022 оны элэгдлийн тооцооллыг хийж, хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тооцооллыг ERP программд оруулах ажлыг СБХ-тэй хамтран хэрэгжүүлсэн.

- 2023 оны 2-р улирлын байдлаар бараа материалын өртөг бодолтод дахин тооцоолол хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар СБХ-ийн хариуцсан нягтлан бодогч болон ерөнхий нягтлан бодогчид өгсөн.

- Татварын маргаан таслах комиссийн хуралд оролцож 266,0 сая төгрөгийн татварын нөхөн төлбөрийн актыг хүчингүй болгосон.

- СБХ-ийн хүсэлтийн дагуу нэр бүхий 10 хүний 2019 оны ээлжийн амралтын тооцоог шалгаж, нийгмийн даатгалын тайланд залруулга хийсэн.

MNS ISO9001:2016 ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТ

“ДЦС-4” ТӨХК-ийн ЧАНАРЫН БОДЛОГО: Бид хүний хөгжлийг эрхэмлэж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах чанарын менежментийн тогтолцооны үр нөлөөг

тасралтгүй сайжруулж, оновчтой горимоор хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцсэн эрчим хүчээр найдвартай хангах.

“ДЦС-4” ТӨХК-ийн 2023 оны Чанарын зорилтын гүйцэтгэл

№	Чанарын зорилт	Дэвшүүлсэн зорилт	Тайлбар	Хувь
1	Чанарын зорилт 1	Нийт ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшинг 60%-д хүргэх	Компанийн хэмжээнд сэтгэл ханамжийн түвшин 65.6 буюу өнгөрсөн оноос 8.7%-аар өсч нийт ажилтнуудын сэтгэл ханамжийн түвшинг 60%-д хүргэх зорилт биелэсэн.	100
2	Чанарын зорилт 2	Ажилтнуудын чадамжийн түвшинг 2.0-оос дээш түвшинд хадгалах	Компанийн хэмжээнд нийт ажилтнуудын чадамжийн дундаж түвшин 2.45 гэсэн үзүүлэлтийг ханган ажилтнуудын чадамжийн түвшинг 2.0-оос дээш түвшинд хадгалан ажилласан.	100
3	Чанарын зорилт 3	“4S”-ийн түвшин хангасан ажлын байрны тоог 60%-аас бууруулахгүйгээр хадгалан хэвшүүлж, ажиллах	4S-ийн түвшин хангасан 591 ажлын байрыг бий болгож 60%-аас бууруулахгүйгээр хадгалан хэвшүүлж ажилласан.	100
4	Чанарын зорилт 4	Байгууллагын эрсдэлийн түвшинг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэх	Алба, хэлтэс, цех нэгжийн Эрсдэлийн түвшинг хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд бууруулж ажилласан.	100
5	Чанарын зорилт 5	Үндсэн тоноглолын тасралтгүй ажиллах дундаж цагийг 1142-д хүргэх	Үндсэн 1519 тоноглолын тасралтгүй ажиллах дундаж цагийг 1-д хүргэсэн.	100
6	Чанарын зорилт 6	Түлшний хувийн зарцуулалтыг 1406 ккал/кВтц хүргэх	Түлшний хувийн зарцуулалтыг 1399 ккал/кВтц хүргэж ажилласан	100
7	Чанарын зорилт 7	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг 98%-д хүргэх	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшин үнэлж 98%-д хүргэсэн	100
Нийт зорилтын гүйцэтгэл				100

Сайн саналын системийн хөтөлбөрийн хэрэгжилт

2023 онд 1064 санал цахим хэлбэрээр ирснээс 957 санал нь сайн саналд тооцогдсон. Сайн санал бичсэн урамшуулалд 957 000 төгрөг зарцуулсан.

Ирүүлсэн саналуудыг ангилалаар нь авч үзэхэд компанийн хэмжээнд ХАБЭМС, болон ажлын байрны орчин сайжруулах саналыг ажилтнууд түлхүү ирүүлэх хандлагатай байна.

Ажлын байрны соёл “5S” хэрэгжилт, тасралтгүй сайжруулалт

2023 оны 1-р сард УДШ-ий хурал зохион байгуулж сүүлийн 4S-ийн түвшин хангасан ажлын байр нэмэгдүүлэх зорилтын биелэлтийг

сүүлийн 5 жилийн гүйцэтгэлийг удирдлагуудад танилцуулсан. УДШ-ний хурлаас гарсан шийдвэрээр 2023 онд “4S”-ийн түвшин хангасан ажлын байрны тоог 60%-аас бууруулахгүйгээр хадгалан хэвшүүлж, ажиллах зорилтыг дэвшүүлэн ажилласан.

2023 оны зорилтондоо Алба, хэлтэс, цех нэгжүүд 4S-ийн түвшин хангасан ажлын байрыг 60%-аас бууруулахгүйгээр хадгалан хэвшүүлж ажиллахаар зорилтоо батлуулсан ажил үр дүнтэй байсан. Нэгжүүдэд ажлын байраа сайжруулах зөвлөмж өгч ажилласан. 5S-ийн шалгах хяналтын хуудас 12 дүгнэх асуумжтай байсныг 23 асуумжтай болгон шинэчлэн сайжруулан ашиглаж байна.

Компанийн хэмжээнд нийт 764 ажлын байр байгаагаас 1S-0, 2S-28, 3S-249, 4S-191, 5S-511 ажлын байр тус тус хангасан байна.

2023 онд нийт компанийн хэмжээнд 770 ажлын байранд сар, улирал бүр Алба, хэлтэс, цех нэгж батлагдсан хяналтын хуудасны дагуу хуваарьт аудитаа зохион байгуулсан.

“5S”-ийн дотоод аудитыг түүврийн аргаар зохион байгуулж, нэгж бүрийн 5S-ийн багууд өөрсдийн төлөвлөгөөний дагуу дотоод аудитаа хийж, тухай бүр санал зөвлөмж, сайжруулах санал гаргаж хамтран ажилласан.

Чанарын дугуйлангийн хэрэгжилт

Компанийн хэмжээнд 119 Чанарын дугуйлан сайн дурын үндсэн дээр ажиллаж байгаа бөгөөд 2023 онд ЗЦ, ТЦ-ийн Чанарын дугуйлангууд багийн шинэчлэл хийн дахин бүртгүүлэн үйл ажиллагаагаа явуулж байна.

2023 оны 12 сард 15 чанарын дугуйлангууд жилийн үйл ажиллагааныхаа тайланг зөвлөлд ирүүлсэн.

Чанарын дугуйлангийн багийн гишүүд ирүүлсэн тайлантай танилцаж багуудын ажлыг дүгнэж шалгаруулалт явуулсан.



2023 ОНД ӨГСӨН ТАРИФЫН САНАЛЫН СУДАЛГАА

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, өртөг зардал нэмэгдсэнтэй холбогдуулж 2023 онд мөрдөх үнэ тарифын саналыг боловсруулж өгсөн.

Үнэ тарифын саналыг ЭХЗХ-ны 2014 оны 231 дугаар тогтоолоор баталсан “Үнэ тариф тооцох аргачлал”-ын дагуу 2020, 2021 оны зардлын гүйцэтгэл, 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2023 оны төсөл, Эрчим хүчний салбарын 2021-2022 оны хамт /тариф/-ын хэлэлцээрийг үндэслэн боловсруулж Эрчим хүчний зохицуулах хороонд 2022 оны 12 дугаар сарын 02-нд 1/1639 тоот албан бичгээр хүргүүлсэн.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 26-ны 105 тоот тогтоолоор

2023 онд цахилгаан, дулааны эрчим хүч борлуулах тарифыг батлуулж мөрдөж ажилласан.

ЭХЗХ-ноос үнэ тариф батлахдаа Борлуулалтын орлогын шаардах хэмжээ /БОШХ/ буюу үйл ажиллагааны зардлыг **394,724.9** сая төгрөгөөр баталж, 2022 оны батлагдсан БОШХ-ээс **87,770.7** сая төгрөгөөр өсөж, компанийн өгсөн саналаас **10,098.1** сая төгрөгөөр бууруулсан. 2023 онд үнэ тарифыг төмөр замын тээврийн тариф, ТАН[№]1-4-ийн нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг шийдвэрлүүлэх, цалин хөлс өссөнтэй холбоотойгоор **3** удаа үнэ тарифыг нэмэгдүүлэх санал өгч, нийт **19,167.5** сая төгрөгөөр БОШХ-г нэмэгдүүлсэн.

2023 онд мөрдөж ажилласан тарифууд

№	Тарифын ангилал	Хэмжих нэгж	Тариф				
			2023.01.26 №105	2023.04.26 №284	2023.09.27 №577	2023.11.22 №638	2023.12.27 №750
1	ЦЭХ-ний тариф	төг/кВтц	77.09	84.18	84.51	86.96	89.43
1.1	Энергийн тариф	төг/кВтц	45.79	45.79	45.82		
1.2	Чадлын тариф	сая.төг/сар	126,926.0	155,653.5	156,863.4		
1.2.1	/1-р улирал/	сая.төг/сар	18,847.3				
1.2.2	/2-р улирал/	сая.төг/сар	6,988.0	9,019.1			
1.2.3	/3-р улирал/	сая.төг/сар	6,988.0	9,019.1			
1.2.4	/4-р улирал/	сая.төг/сар	9,485.3	14,999.1	15,402.4		
1.2.5	/11-р сар/	сая.төг/сар				20,374.2	
1.2.6	/12-р сар/	сая.төг/сар					30,374.2
2	ДЭХ-ний тариф	төг/Гкал	13,447.83	6,794.73			
2.1	1-р улиралд	төг/Гкал	16,998.41				
2.2	2-р улиралд	төг/Гкал	4,731.08	628.02			
2.3	3-р улиралд	төг/Гкал	4,731.08	628.02			
2.4	4-р улиралд	төг/Гкал	16,098.25	628.02			


Хэрэглэгчийг шууд хангах тарифууд

Хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний үнэ тариф 2022 оны 11 сард өөрчлөгдөж 12 сараас мөрдөж эхэлсэн. Цахилгаан эрчим хүчний хэрэглээний түвшингээр нь ангилал нэмж **5000** кВт.ц-аас ихгүй хэрэглээг **164.00** төг/кВтц, чадлыг **10,260** төг/кВт/сар, **5000** кВт.ц-аас их хэрэглээг **210.79** төг/кВтц, чадлыг

11,520 төг/кВтц сараар, ДЭХ-ний хэрэглэгчдийн тариф **38,995.86** төг/Гкал-аар, уурын хэрэглэгчдийн тариф **28,928.00** төг/Гкал-аар тус тус мөрдөн ажиллаж байна. Харин сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тариф **23.79** төг/кВтц

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЭХ ҮҮСВЭРҮҮДИЙН 2023 ОНЫ ҮНИЙН СУДАЛГАА

№	Эх үүсвэрүүд	2022 он	2023 он	Өсөлт/бууралт
		Дундаж тариф, төг/кВтц		
1	ДУЛААНЫ IV ЦАХИЛГААН СТАНЦ	61.41	87.37	42.3%
2	ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦ	106.49	145.70	36.8%
3	ДУЛААНЫ II ЦАХИЛГААН СТАНЦ	164.65	231.14	40.4%
4	ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	142.64	176.87	24.0%
5	ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	136.33	185.59	36.1%
6	УХАА-ХУДАГ ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	191.44	191.44	0.0%
7	ГОК ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	129.29	153.76	18.9%
8	ДАЛАНЗАДГАДЫН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	185.69	200.00	7.7%
9	ИМПОРТ	302.79	243.83	-19.5%
10	САЛХИН ЦАХИЛГААН СТАНЦ	300.69	327.71	9.0%
11	НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ	495.43	543.32	9.7%



КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ, Эрчим хүчний системд эзлэх байр суурь

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

08

Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын зөвлөл

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

12

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн биелэлт, Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай, Засварын ажлын талаар, Техник, технологийн шинэчлэл, төсөл

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

20

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын санал, дүгнэлт, Аудитлагдсан санхүүгийн тайлан, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн чадавхийн шинжилгээ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд, Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр

47

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

Хүний нөөц, Ил тод, ёс зүйн байдал, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

41

31

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар, Санхүүгийн дотоод аудит, MNS ISO9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт, Тарифын зохицуулалт, Эрчим хүчний эх үүсвэрүүдийн 2023 оны үнийн судалгаа

ХҮНИЙ НӨӨЦ

2023 онд компани хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр нийт **1487** ажилтантай ажиллалаа. **722** ажилтан буюу **48.5%** нь дээд, **144** буюу **9.7%** нь тусгай дунд, **621** буюу **41.8%** нь бага, бүрэн бус дунд болон бүрэн дунд боловсролтой бөгөөд ажилтнуудын **24.3%** буюу **362** ажилтан нь эмэгтэй ажилтнууд байна.

Ажилтнуудын насны ангилал:

- 18-25 насны - **171** ажилтан
- 26-35 насны - **412** ажилтан
- 36-50 насны - **656** ажилтан
- 51-60 насны - **247** ажилтан
- 60-аас дээш насны - **1** ажилтан



Ажилтнуудын ажилласан жил:

- 0-5 жил - **510** ажилтан
- 6-10 жил - **224** ажилтан
- 11-15 жил - **199** ажилтан
- 16-20 жил - **210** ажилтан
- 21-ээс дээш жил - **344** ажилтан

Мэдээллийн систем

Компанийн үйл ажиллагааны мэдээллийг бүх ажилчдад ил тод, үнэн зөв, шуурхай хүргэх зорилгоор мэдээллийн цогц системийг тогтмол ажиллуулж байна. Үүнд:

- Дотоод сүлжээ буюу Inbit мессенжер
- Мэдээлэл түгээх дэлгэцүүд
- Компанийн цахим хуудас
- Компанийн facebook page, group
- Телеграм мессенжер




Аливаа арга хэмжээ, үйл явдлын мэдээллийг цаг хугацаанд нь зураг, бичлэгтэйгээр боловсруулан компанийн доорхи цахим хуудаснуудад 10 гаруй мэдээллийг оруулсан ба энэхүү үйл ажиллагаануудын баримт файлууд нийт 48 хавтас /250 GB орчим/ болон архивлагдсан.

- www.tpp4.mn
- www.facebook.com/thermalpowerplant4/
- www.facebook.com/groups/ThermalPowerPlant4/

ИЛ ТОД, ЁС ЗҮЙН БАЙДАЛ

Худалдан авах ажиллагааны талаар

2023 оны 1-р сарын 23-наас эхлэн засварын ажлын тендерүүд зарлагдаж тухайн оны худалдан авах үйл ажиллагаа эхэлсэн. Бид “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн хүрээнд 2023 онд давхардсан тоогоор 408 ш тендер шалгаруулалтуудыг олон нийтийн хүрээнд нээлттэйгээр /цахимаар/ ил тод хэлбэрээр 127 ш НТШ-тэй, 112 ш үнийн саналын харьцуулалт явуулж, нийт 60,557 сая төгрөгийн бараа худалдан авалтыг зохион



байгуулсан байна. Биелэлт 98%-тай байна.

2023 оны 3-р сарын 30-ны байдлаар төлөвлөгөөний дагуу нийт 200 ш тендерүүдийг зарлаж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хийхэд мөн үнийн өсөлтөд орохгүй байх боломжийг ханган ажилласан. Нээлттэй тендер шалгаруулалтыг төлөвлөгөөний дагуу 100% зарласан ба зөвхөн жилийн турш нийлүүлэгддэг материалын тендерүүд хугацаагаа хүлээн зарлахаар үлдсэн.

Нээлттэй болон харьцуулалтын тендер

шалгаруулалт бүрийг “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем”-ээр дамжуулан 408 удаа цахимаар зарласан. Нийт худалдан авалтын 80%-ийг нээлттэй тендер шалгаруулалт /НТШ/, 7.5%-ийг харьцуулалтын худалдан авалт /ХХА/, 9.8%-ийг шууд гэрээ байгуулах /ШГБ/, 1,3 %-ийг шууд худалдан авалт /ШХА/ эзэлж байна. Худалдан авах ажиллагааг www.tender.gov.mn бүхий цахим системээр 87.5%-ийг зохион байгуулсан байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

1. Байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Монгол улсын байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг мөрдлөг болгон “ДЦС-4” ТӨХК-ийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан хөтөлбөр, зөвлөмжийн дагуу ажлаа зохион байгуулж, байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөөг хуулинд нийцүүлэн боловсруулж БОАЖЯ-аар батлуулсан.

Байгаль орчныг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд 233.5 сая төгрөгийн төсөв бүхий 28 ажил хийхээр батлагдсан. Төлөвлөгөөний биелэлт – 83,3%. Үүнд:

№	Ажлын чиглэл	Биелэлт	
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	9 ажил	100%
2	Орчны тохижилт, нөхөн сэргээх арга хэмжээ	4 ажил	100%
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	3 ажил	100%
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	4 ажил	100%
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	7 ажил	100%
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1 ажил	0%
Нийт дүн		28 ажил	83,3%

Тайлбар: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдээгүй.

2. Агаарын бохирдлоос сэргийлэх талаар

2.1 Утааны хийтэй агаарт хаягдсан хий, үнсний хэмжээ

2023 онд 4207865 тн нүүрс түлж, агаар мандалд 12076 тн дэгдэмхий үнс, 16284 тн азотын исэл NO_x , 9215 тн хүхрийн исэл SO_2 , 126 тн CO -нүүрстөрөгчийн дутуу исэл хаясан.

Сар бүр ажиллагаанд байсан зуухнуудын утааны хийн найрлага дахь хорт бодисын хэмжилтийг үндэслэн массын болон эзэлхүүний агууламжийг тодорхойлсон.

Хорт бодисуудын агууламжийг MNS 5919:2008 стандарттай харьцуулахад, нүүрстөрөгчийн дутуу исэл (CO), азотын исэл (NO_x), хүхрийн исэл (SO_x), дэгдэмхий үнсний хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрээгүй.


Утааны хийтэй агаарт хаягдаж байгаа үнс ба хийнүүдийн хэмжээ, г/с

Хий, үнс	NO_x	SO_2	CO	Дэгдэмхий үнс
MNS 5919:2008	67 г/с	112,5 г/с	18,3 г/с	200 мг/нм ³
К-1	26,6	74,72	0,02	
К-2	30,0	91,6	0,3	
К-3	27,7	92,7	0,2	
К-4	31,0	93,9	0,04	
К-5	25,9	59,5	0,08	
К-6	26,5	61,7	0,03	
К-7	25,6	58,5	0,04	
К-8	30,3	59,3	0,1	
Дундаж	28,0	73,97	0,10	40,35

Агаарын чанарын үзүүлэлтийг агаарын чанарын индексээр тооцвол:

51-100: Агаарын чанар дунд зэрэг (дунд зэргийн нөлөөг үзүүлнэ). Хүлээн зөвшөөрөгдөх боломжтой, гэвч зарим бохирдуулагч цөөн хүмүүсийн эрүүл мэндэд дунд зэргийн нөлөө үзүүлнэ.

Утааны хийтэй агаарт хаягдсан хий болон үнсний судалгаа, г/с



2.2 Цахилгаан шүүлтүүрийн ажиллагаа

- Зуухнуудын ажилласан цаг - 47650
- Цахилгаан шүүлтүүрийн ажилласан цаг - 45383
- Цахилгаан шүүлтүүрийн үнс барих чадвар - 96,74%

Цахилгаан шүүлтүүрийн үнс барих чадвар (%)

Он	2019	2020	2021	2022	2023
К - 1	98.34	95.53	98.61	97.69	98.72
К - 2	93.72	96.18	98.07	94.39	96.92
К - 3	98.07	97.93	97.29	94.16	97.8
К - 4	98.08	97.42	98.13	97.65	98.54
К - 5	99.33	98.09	98.13	93.85	96.64
К - 6	94.65	92.89	97.65	94.37	94.43
К - 7	98.49	97.85	97.43	97.56	93.74
К - 8	96.59	96.78	97.64	91.4	97.16
Дундаж	97.16	96.58	97.87	95.13	96.74

Цахилгаан шүүлтүүрийн үнс барих чадвар өмнөх оноос 1,6 %-аар нэмэгдсэн.

2.3 Үнс авч ашигласан тухай

Цахилгаан шүүлтүүрийн хуурай үнс ашиглахаар хүсэлт тавьсан иргэн, аж ахуй нэгжүүдийн бүтээгдэхүүнд цацрагийн шинжилгээ хийлгэж, Цөмийн энергийн газрын Улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр олгож байна.

2023 онд барилгын материалын үйлдвэрлэл худалдаа эрхлэгч нийт 32 компанитай “Хуурай үнс худалдах, худалдан авах гэрээ” байгуулан ажиллаж нийтдээ 52725 тн үнс нийлүүлсэн нь өмнөх оныхтой харьцуулахад 14217 тн-оор буурсан байна.

Үнсэн сангаас үнс авч ашиглах гэрээний дагуу 10000 тонн орчим үнс олборлосон.

2.4 Хяналтын худаг, усны шинжилгээ

Хяналтын худаг №1,2 болон гүний худгийн усны шинжилгээг сар бүр ХЦ-ийн лабораторид хийлгэж, хяналт тавьсан.

Ундны усны дээжинд улирал тутам хийгдсэн СХЗГ-ын ХАБҮЛЛ-ийн микробиологийн лабораторийн шинжилгээгээр стандартын шаардлагад тусгагдсан үзүүлэлтээс хэтэрсэн тохиолдол байхгүй байна.

ЭЗЦГ-ын усны шинжилгээний үр дүн (2023.08.24)

Элемент	Хэмжих нэгж	Шинжилгээний дүн	Зөвшөөрөгдөх хэмжээ
Аммони	мг/л	0,0	< 1,5
Кальци	мг/л	70,1	< 100,0
Магни	мг/л	4,9	< 30,0
Төмөр	мг/л	0,05	< 0,3
Нитрат	мг/л	11,4	< 50,0
Нитрит	мг/л	0,004	< 1,0
pH	-	7,1	6,5-8,5
Сульфат	мг/л	128,0	< 500,0

Элемент	Хэмжих нэгж	Шинжилгээний дүн	Зөвшөөрөгдөх хэмжээ
Хатуулаг	мг-экв/л	3,9	< 7,0
Хлорид	мг/л	15,5	< 7,0
Хуурай үлдэгдэл	мг/л	302	< 1000,0
ЦДЧ	мСм/см	0,4	< 7,0
ББЕТ	мг/л	27	1 мл-д < 100
Гэдэсний бүлгийн нян	мг/л	илрээгүй	100 мл-д илрэхгүй
Сальмонелл-лөз	мг/л	илрээгүй	25 мл-д илрэхгүй

2.5 Химийн бодисын хадгалалт, хамгаалалт

Хадгалагдаж байгаа химийн бодисуудыг вакуум уутаар вакуумдаж агаарт тархах эрсдэлийг бууруулан хадгалсан. Тухайн жилд химийн бодис нийлүүлсэн компанид химийн бодисын сав баглаа боодлыг тэр жилд нь буцаан өгч ажиллах, тендерийн бичиг баримтад тусгагдсан.

3. Хог хаягдлын тухай

1. Зуухан цехийн мазутын бакыг цэвэрлэхэд гарсан 4770 кг мазутын шаарыг Монгол улсын "Хог хаягдлын тухай" хуулийн 10.2.17-д заасны дагуу станцын нутаг дэвсгэрээс гаргаж зориулалтын уурын зууханд шатааж устгасан.
2. "Элемент медиал" ХХК-тай Д/2023-30 тоот гэрээ байгуулан эмнэлгийн хог хаягдлыг устгалд оруулж ажилласан.
3. "Хот тохижуулах газар" ОНӨААТҮГ-тай Д/2023-210 тоот гэрээ байгуулан СХД-ийн төвлөрсөн хогийн цэгт 1069 тн ахуйн хог хаягдлыг тээвэрлэж хаясан.
4. Үнсэн санд 316592 тн үнс, 15109 тн шлакийг тээвэрлэж хаясан.

4. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажил

4.1 Утааны хийн хэмжилт

1. Зуухны утааны хийтэй агаарт хаягдаж байгаа NO_x , SO_2 , CO , CO_2 , O_2 -н хэмжээг утааны хийн анализатор ENDA-5800, дэгдэмхий үнсний хэмжээг DDM-fc тоосонцрын агууламж хэмжигчээр хэмжсэн. Хэмжилтийн үр дүнг "РД 34.02.305-98 ДЦС-ын зуухны агаар мандалд хаях бохирдуулагч бодисын хэмжээг тодорхойлох аргачлал"-ын дагуу тодорхойлж ажилласан.

4.4 Трансформаторын тосны шинжилгээ

Трансформаторын тосны шинжилгээг улирал тутам ЭХҮТ-ийн эрчим хүчний нэгдсэн лабораторид хийлгэсэн. Трансформаторын тосонд хийсэн химийн ерөнхий шинжилгээний

Трансформаторын тосны шинжилгээний үр дүн

Үзүүлэлт (ppm)	Стандартын шаардлага	2023.05.26 шинэ Т	2023.05.26 7Т	2023.10.17 6ВТ	2023.10.17 6Т
Өнгө	-	Шар туяатай	Өнгөгүй	Гүн шар	Гүн шар
Тунгалагжилт	Тунгалаг	-	-	-	-
Механик хольц, %	Үгүй	үгүй	Үгүй	үгүй	үгүй
H_2 - устөрөгч	150-аас ихгүй	0,00	0,75	0,00	0,00
CO - нүүрстөрөгчийн исэл	-	17,75	1286,19	67,98	143,64
CO_2 - нүүрстөрөгчийн давхар исэл	-	77,86	12919,21	1782,76	8405,08
CH_4 - метан	40-өөс ихгүй	0,48	31,01	0,84	5,96
C_2H_4 - этилен	35-аас ихгүй	0,53	26,66	3,43	3,87
C_2H_6 - этан	70-аас ихгүй	0,09	3,61	1,47	0,36
C_2H_2 - ацетилен	5-аас ихгүй	0,19	0,46	0,26	0,19
Нийт	150-аас ихгүй	1,29	61,74	6,01	10,38

4.2 Нүүрс, үнсний элементийн шинжилгээ

Багануур, Шивээ-Овоогийн нүүрс, үнсний дээж авч "Миллениум ресурс" ХХК-ийн нүүрсний шинжилгээний лабораторид хийлгэсэн. (2023.07.20)

Үзүүлэлт	C, %	H, %	N, %	S, %
Багануур хүрэн нүүрс	63.1	4.12	0.78	0.89
Шивээ-Овоо хүрэн нүүрс	60.9	4.18	0.92	1.15

4.3 Цацраг идэвхийн шинжилгээ

Багануур, Шивээ-Овоогийн нүүрс, цахилгаан шүүлтүүрийн үнс, үнсэн сангийн үнс, хөрснөөс дээж авч, СХЗГ-ын ХАБҮЛЛ-ийн цацрагийн хяналтын лабораторид цацраг идэвхт изотопуудын хувийн идэвх тодорхойлох шинжилгээнд хамруулсан. (2023.06.15)

Үнсний цацрагийн шинжилгээний дүн

Сорьц	Изотопуудын хувийн идэвх, Бк/кг			
	K-40	Cs-137	U-238	Th-232
Нүүрс (Багануур)	89 ± 16	$\leq 0,6$	79 ± 10	20 ± 3
Нүүрс (Шивээ-Овоо)	280 ± 22	$\leq 0,6$	18 ± 3	6 ± 1
Хөрс (Үнсэн сан)	869 ± 90	$2,6 \pm 0,9$	83 ± 10	29 ± 4
Хөрс (Зуухны хойд тал)	1034 ± 105	$\leq 0,6$	23 ± 3	24 ± 3

үр дүнгээс үзэхэд тосонд ууссан хийнүүдийн агууламж MNS JIS K 014:2003, MNS IEC 60599:2016 стандартын шаардлага хангаж байна.

Ногоон байгууламж нэмэгдүүлэх, байгаль орны хамгаалах ажлын хүрээнд:

Компанийн хашаанд одоогийн байдлаар бутлаг ургамал 35 624 ширхэг, модлог ургамал 2489 ширхэг бүгд 38 113 ширхэг ургамал ургаж байна.

2023 онд ногоон байгууламж нэмэгдүүлэх ажилд 25 813 300 төгрөгийг компанийн төлөвлөгөөнд тусгаж 910ш модны үрсэлгээ болон дагалдах материалыг худалдан авч шинээр тариалав.

Өөрсдийн бэлтгэсэн 27 кг цэцгийн үрээр 189,12 м² талбай бүхий цэцгийн мандлыг тариалж, шинээр 350 м² талбайг зүлэгжүүлэв.



Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар хэрэгжиж буй “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дундговь аймгийн Дэлгэрцогт, Луус суманд 1 472 ширхэг модыг 108 544 800 төгрөгийн хөрөнгө оруулалтаар тарьж ургуулж байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнгийн хуваарьт талбайд 11 ш модыг шинээр тариалав.

2025 оноос компанийн хэрэгцээнд тарьж ургуулах үрсэлгээг дотоод нөөц боломжоо ашиглан бэлтгэх зорилтын хүрээнд 7 нэр төрлийн үрсэлгээг зориулалтын талбайг бэлтгэн тариалж байна.



КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Товч танилцуулга, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ, Гүйцэтгэх захирлын мэндчилгээ, Эрчим хүчний системд эзлэх байр суурь

04

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

08

Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирлын зөвлөл

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

12

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот туашингийн биелэлт, Техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн тухай, Засварын ажлын талаар, Техник, технологийн шинэчлэл, төсөл

20

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын санал, дүгнэлт, Аудитлагдсан санхүүгийн тайлан, Орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Санхүүгийн чадавхийн шинжилгээ

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Нийгмийн асуудалд чиглэсэн ажлууд, Соёл урлаг, олон нийтийн үйл ажиллагааны чиглэлээр

47

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАГНАЛ

Хүний нөөц, Ил тод, ёс зүйн байдал, Байгаль орчныг хамгаалах чиглэлээр

41

31

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Хөдөлмөрийн асуулгүй байдлын талаар, Санхүүгийн дотоод аудит, MNS ISO9001:2016 Чанарын менежментийн тогтолцоо стандартын хэрэгжилт, Тарифын зохицуулалт, Эрчим хүчний эх үүсвэрүүдийн 2023 оны үнийн судалгаа

НИЙГМИЙН АСУУДАЛД ЧИГЛЭСЭН АЖЛУУД

2023 онд **370** хүнд **4,954.6** сая төгрөгийн буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшуулал, нөхөн төлбөр олгосон байна.

2023 онд “ДЦС-4” ТӨХК-ийн ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд тус компанид олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа **50** ажилтанд орон сууцны асуудлаа шийдвэрлэхэд тус бүрт нь арван таван сая төгрөгийн дэмжлэгийг олгосон.


Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, Олон Улсын ахмадын өдрийг тохиолдуулан ахмад настнууддаа **82.55** сая төгрөгийн тэтгэмжийг олгосон.

“ДЦС-4” ТӨХК-ийн Захиргаа, Үйлдвэрчний Эвлэлийн Хороотой байгуулсан Хамтын гэрээний дагуу **312** ажилтан, **116** хөдөлмөрийн чадвар алдалтын хувь

тогтоогдсон ажилтан болон өндөр настанд халаалтын улирлын хөнгөлөлт тус бүр **100,000** төгрөг буюу нийт **42.8** сая төгрөгийг олгосон.

2023 онд нийт **24** хөгжлийн бэрхшээлтэй болон одой иргэдийг ажлын байраар хангаж, хөдөлмөр хамгааллын хувцас, хөдөлмөрийн багаж хэрэгсэл, боломжит ажлын орчин нөхцлөөр хангаж ажиллаж ирлээ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон үйлдвэрийн осол, хурц хордлогод өртсөн **46** ажилтанд тус тус **60,000** төгрөг, Монгол Улсын нэрийн өмнөөс Параолимпод оролцон мөнгөн медаль хүртсэн **1** иргэнд I зэргийн мөнгөн шагнал **300,000** мянган төгрөг, сайн ажилласан тэргүүний **1** ажилтныг II зэргийн мөнгөн шагнал **260,000** мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нийгмийн халамжид хамрагдсан хүний тоо, зардал /сая.төг/




Урьдчилан сэргийлэх үзлэг

2023 онд ХАБЭМ-ийн тухай хуулийн 14-р зүйлийг үндэслэн “ДЦС-4” ТӨХК-ийн ажилтнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх байгууллагыг ХААХэлтэсээс нээлттэй тендерээр **3** удаа зохион байгуулж, сонгон шалгаруулалтаар “Итгэл Эрүүл Мэнд” эмнэлэг шалгаран, уг үзлэгийг 2023 оны 10 сарын 16-ны өдрөөс 11 сарын 10-ны өдрийг дуустал зохион байгууллаа.

Лабораторийн шинжилгээнд **1211**, Ходоод, улаан хоолойн дурангийн шинжилгээнд **207**, хэвлийн эхо шинжилгээнд **501**, цээжний

Нийгмийн халамжийн зардлын бүтэц



рентгенд **664**, зүрх судас уушигны эмчийн үзлэгт **771**, дотрын эмчийн /хоол боловсруулах/ үзлэгт **312** ажилтан тус тус хамрагджээ.

Үзлэг, шинжилгээгээр өөрчлөлттэй гарсан, дахин нарийвчилсан шинжилгээ хийлгэх шаардлагатай **55** ажилтныг “Итгэл Эрүүл Мэнд” эмнэлгээс ходоод болон элэгний хавдрын маркер илрүүлэх шинжилгээнд үнэ төлбөргүйгээр хамруулсан.

СОЁЛ, СПОРТ, ОЛОН НИЙТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Байгууллагын алба хэлтэс, цех, нэгжүүдийн соёл урлаг, олон нийтийн ажлуудад хурлын заал танхим тайз дэлгэц, техник хэрэгсэл, аппаратаар тогтмол үйлчлэн бэлэн байдлыг хангаж ажиллаж “Дөл” танхимд 140 удаагийн үйл ажиллагааны явцад давхардсан тоогоор 7780 хүн, “Алдар”-ын танхимд 274 удаагийн хурал зөвлөгөөн, тэмцээн уралдаан үйл ажиллагаанд давхардсан тоогоор 4351 хүн хамрагдав.

- Тус хугацаанд МУ-ын Ерөнхий сайд, ЭХ-

ний сайд болон бусад удирдлага, зочид төлөөлөгчдийг ирэх үед болон сурталчилгаа, ээлжит бус хурал, цуглаан, уулзалт, компанийн аварга шалгаруулах тэмцээнүүд, тендерийн нээлт зэрэг олон нийтийн ажлуудад аппарат, техник хэрэгслийн найдвартай ажиллагааг ханган ажиллав.

- МУ-н ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, ЭХ-ний сайд Б.Чойжилсүрэн нарын Эрчим хүчний салбарын хамт олонтой хийсэн “Өглөөний уулзалт”-ыг зохион байгуулав.



- Сар шинийн золголтын үйл ажиллагааг 2023 оны 02 сарын 24 өдөр ЭЗГ-т зохион 300 гаруй ажилчдыг хамруулав.



- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг 2023 оны 03-р сарын 07-ны өдөр UG арена төвд зохион байгуулж нийт 600 гаруй хүн оролцов.



Компанийн 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд зохион байгуулсан олон нийтийн арга хэмжээ

Компанийн 40 жилийн ойг зохион байгуулах ажлын хэсэг, дэд хэсгүүдийг гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулж, ажлын хэсэг тус бүрээр ажлын төлөвлөгөөг гаргуулан ажиллав.

Урлагийн наадам:

Компанийн ажилчдын урлагийн наадмыг 2023 оны 05 сарын 25-26 өдрүүдэд Эрчим-2 зааланд зохион байгуулав. Батлагдсан удирдамжийн дагуу гоцлол дуу, гоцлол бүжиг, гоцлол хөгжим, найрал болон цөөхүүл дууны



Хүндэтгэлийн тоглолт:

Урлагийн наадмаас 68 шилдэг уран сайханч ажилчдыг шалгаруулан авч үндсэн ажлаас чөлөөлөн дуу анги, бүжиг анги, хөгжим анги болгон хуваарьлаж бэлтгэл сургуулиалт хийх байр, талбай, техник хэрэгслээр ханган нэгдсэн хүндэтгэлийн тоглолтыг Монгол Улсын Соёлын төв өргөөнд 2023 оны 09 сарын 14-ний өдөр нийт ахмадуудад, 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр компанийн нийт ажилтнууд болон ойн үйл ажиллагаанд урилгаар оролцсон хүндэт зочдод өргөн барив.



хамтлаг, цөөхүүл бүжгийн хамтлаг, цөөхүүл хөгжмийн хамтлаг, язгуур урлаг гэсэн 7 төрлөөр 7 цех, захиргааны нийт 8 баг өрсөлдөв.

Тус наадмыг УДЭТеатрын найруулагч, жүжигчин М.Түвшинхүү, ЦДБЭЧ-ын гоцлол дуучин, МУГЖ Б.Батбаатар, ЦДБЭЧ-ын дэд дарга, дэд хурандаа, Бүжиг дэглээч Л.Баттөр нар шүүн явуулав.

Нэгдсэн дүнгээр Урлагийн наадмын шилдгийн шилдэг хамт олоноор Турбин цех шалгарсан бол Гран при буюу шилдэг үзүүлбэрээр захиргааны багийн "Хөдөөгийн залуус" хамтлаг бүжиг шалгарав.



Эрчим хүчний ажилчдын өдөр:

Эрчим хүчний ажилтны өдөр, компанийн 40 жилийн ойн баяр наадмыг 2023 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Богдхан уулын Түргэний аманд зохион байгуулав.

Тус баярын арга хэмжээний үеэр үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, шагайн харваа, дээлтэй монгол зэрэг спорт урлагийн арга хэмжээнүүд болон урлагийн хамтлаг дуучдын тоглолтуудыг толилуулав.



Спортын уралдаан, тэмцээн:

2023 оны Компанийн “Спортын аварга хамт олон” шалгаруулах тэмцээн нь “ДЦС-4” ТӨХК үүсэн байгуулагдсаны түүхт 40 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж тэмцээнийг шинэлэг, өвөрмөц байдлаар зохион байгуулж ажиллав.

Онцлогуудаас дурдвал:

- Шагналын сан 3 дахин нэмэгдсэн. Өмнөх жилүүдэд багийн төрлөөр тэргүүн байр эзэлсэн баг 500 000 төгрөгийн шагнал хүртэж байсан бол энэ жил 2 000 000 сая төгрөгийг хүртэв.
- Сагсан бөмбөгийн тэмцээнийг Спрайт лигийн тэмцээний дүрмээр зохион байгуулсан нь ажилчдыг олноор хамруулах, залуу тамирчдын авьяасыг нээх зорилготой байв.
- Тэмцээн уралдааны үеэр маскот, бэлгэдлүүдийг ажиллуулж, шууд дамжуулалт, Залуучуудын холбооны асуулт хариулт, АХА тэмцээн зэрэг нэмэлт үйл ажиллагаануудыг зохион байгуулав.
- Тэмцээний нэгдсэн арга хэмжээг 2023 оны 04 дүгээр сард Хандгайт дах Их тамир спорт цогцолборт спортын 4 төрлөөр зохион байгуулж 120 орчим ажилчид тамирчдыг хамруулав.

9 төрөлт тэмцээний нийлбэр дүнгээр 2023 оны компанийн спортын аварга хамт

олноор Л.Ганболд даргатай Зуухан цех шалгарав.

Компанийн дэргэдэх “Эрчим” волейболын эмэгтэй клубын баг тамирчид төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ивээн тэтгэгч байгууллагатай хамтран 2023-2024 оны МВХ-ны “Үндэсний дээд лиг”-ийн тэмцээнд АНУ-аас Aniya Nicole Williams, Их Британи улсаас Lauren Rhiannon Cadwgan, Бүгд Найрамдах Куба улсаас Arlin Hechavarría Correoso нарын 3 легионер тамирчныг урьж тоглуулан 11 дэх удаагаа аваргын алтан медаль хүртэв.

2023 онд “Эрчим” хөлбөмбөгийн клубт 10-60 насны 200 гаруй тамирчид МХБХ-ы үндэсний “Моби-Пример дээд лиг”, 1-р лиг, U-14,16,19 насны лиг, 10, 11, 12 хүртэлх насны хүүхдийн грассрүүтс тэмцээн, МХБХ-ны ахмад мастеруудын УАШТ, УБ-хотын аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилттай оролцов.

2023 оны “Олс таталт”-ын улсын аварга шалгаруулах тэмцээнд “ДЦС-4” ТӨХК-ийн “Эрчим” олс таталтын баг аваргын алтан медаль хүртэв.

Ширээний теннисны ахмадын Ази тивийн аварга шалгаруулах тэмцээнд СБХ-ийн нөөц бүртгэлийн нярав, ОУХМ Ц.Наранцацрал хосын төрөлд алтан медаль, ганцаарчилсан төрөлд мөнгөн медаль хүртэв.





Хаяг:

“Дулааны IV Цахилгаан Станц” ТӨХК-18080

Баянгол дүүрэг, 20-р хороо, Эрчим хүчний гудамж, Улаанбаатар хот, Монгол Улс, Ш/х-37

Факс : (976)-7028-1819 Утас : 7000-1284

Вэб хаяг: <http://www.tpp4.mn>

Эл.шуудан: info@tpp4.mn